## НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНГИЙН ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТИЙН ТОВЧОО

**2021.12.25** **Багахангай дүүрэг**

| № | Агуулга | | Бүгд | НЭГ. "Ковид-19" цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого | ХОЁР. Хүний хөгжлийн бодлого | ГУРАВ. Эдийн засгийн бодлого | ДӨРӨВ. Засаглалын бодлого | ТАВ. Ногоон хөгжлийн бодлого | ЗУРГАА. Нийслэл ба бүс орон нутгийн хөгжлийн бодлого | ХОЁР. байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | **Нийт заалтын тоо** | | **138** | **7** | **32** | **21** | **31** | **11** | **13** | **23** |
| 2 | Үнэлгээний дүн | | 94.2 % | 95.7% | 95.3% | 92.8% | 96% | 100% | 82.3% | 97.3% |
| 3 | Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол | 100% бүрэн биелэсэн | 103 | 6 | 27 | 16 | 25 | - | 9 | 20 |
| | | Хэрэгжих шатанд 70% | 20 | 1 | 5 | 5 | 5 | - | 2 | 2 |
| | | Хэрэгжилт хангалтгүй 30% | 2 | - | - | - | 1 | - | 1 | - |
| | | Тасарсан 0 | 1 | - | - | - | - | - | 1 | - |
| 4 | | Хэрэгжилтийн хугацаа тооцох болоогүй | - | - | - | - | - | - | - | - |
| Үнэлгээний нийт хувь 94.2% "Тодорхой үр дүнд хүрсэн" | | | | | | | | | | |

ХЯНАСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Л.САНЖИЙЖАМЦ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ЭРХ ЗҮЙ, ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ-ҮНЭЛГЭЭ,
ХӨРӨНГӨ ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН С.ЦЭНД-АЮУШ

НЭГТГЭСЭН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН Х.ЦЭЦЭГСҮРЭН

**НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН**
**2021 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**
/2021 оны жилийн эцсийн байдлаар/

2021 оны 12 дугаар сарын 24 — Багахангай дүүрэг

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж /ДЗДҮАХ/ | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь | Үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| НЭГ. ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ ТУСГАГДСАН ҮЙЛ АЖИЛЛАГАА | | | | | | | | |
| 1. "КОВИД-19" ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО | | | | | | | | |
| Зорилт 1.1. Цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна. | | | | | | | | |
| 1. | Цар тахлаас урьдчилан сэргийлэх болон өвчний тохиолдол нэмэгдсэн үед дүүргийн Эрүүл мэндийн төвийн бэлэн байдлыг хангах, онцгой нөхцөлд ажиллах албан хаагчдад хамгаалалтын хувцсыг олгох, шаардлагатай эм эмийн хэрэгсэл, тусгаарлан ажиглах байр, хээрийн эмнэлэг дэлгэх бэлэн байдлыг хангах | 5.0 сая төгрөг, дүүргийн төсөв | Зарцуулсан хөрөнгө | 2020 онд коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангах чиглэлээр 9,8 сая төгрөг зарцуулсан. | Цар тахлаас урьдчилан сэргийлэх бэлтгэл бэлэн байдал хангагдсан байна. | Дүүргийн хэмжээнд "Нэг хаалга-Нэг шинжилгээ" арга хэмжээг 2 удаа зохион байгуулж байнгын болон явуулын цэгүүдийг байгуулж давхардсан тоогоор 2648 иргэдийг шинжилгээнд хамруулж ажиллав. Дүүргийн Засаг даргын 2021 оны А/27 дугаар захирамжаар 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрөөс дүүрэгт дархлаажуулах ажлыг эхлүүлэв. 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн байдлаар I тунд 3124 /95,3%/, II тунд 2825 /90,4%/, III тунд 1164 /37,3%/ иргэн хамрагдсан байна. Дархлаажуулалтад иргэдийг идэвхтэй хамруулах зорилгоор хороодын хэсгийн ахлагч нарын дунд аян зарлах, явуулын нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, дархлаажуулалтад хамрагдахыг уриалсан мэдээллийг бүхий л хэлбэрээр явуулах зэрэг арга хэмжээг авч ажиллав. Коронавируст халдвар /Ковид-19/-ыг эмчлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангаан Эрүүл мэндийн төвд 16 ор дэлгэн тус ороор 266 хүнийг эмчилж эрүүлжүүлсэн байна. Мөн эрүүл мэндийн төвд хүчилтөрөгчийн баллон, 10ш төгсгөвч байршуулж 279 иргэнд хүчилтөрөгчөөр үйлчилсэн байна. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ болон Ковид /19/-ийн эмчилгээнд шаардлагатай 197.5 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах | 100 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хувцасны нөөцийг бүрдүүлж ажиллав.<br>Дүүрэгт тусгаарлан ажиглах байрыг ЖДҮДТ, Авдрын гол овоо ХХК-ийн Аривжих байр байхаар шийдвэрлэн гэрээ байгуулж, бэлтгэл бэлэн байдлыг хангаж ажиллалаа. | | |
| 2. | Нөхцөл байдлын мэдээллийг дүүргийн иргэдэд үнэн зөв, бодитой, нэг эх сурвалжаас хүргэх, коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмжийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол хүргэх | - | Мэдээлсэн мэдээллийн тоо | Багахангай хэвлэл мэдээлэл болон холбогдох ААНБ-ын facebook хуудсаар мэдээллийг хүргэж ажилласан. | Дүүргийн иргэдийг коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж мэдээллээр хангасан байна. | Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар цахлаас урьдчилан сэргийлэх талаар цаг үеийн холбогдолтой 483 мэдээлэл, 35 видео контент бэлтгэн дүүргийн www.bagakhangai.ub.gov.mn вэбсайт, Багахангай хэвлэл мэдээлэл facebook хуудсанд байршуулж, цаг үеийн нөхцөл байдлын талаар 11 удаагийн live мэдээллийг иргэдэд хүргэв.<br>Мөн дүүргийн Эрүүл мэндийн төв нь цахим хуудсандаа 327 мэдээллийг байршуулсан байна. | 100 | 100% |
| 3. | Коронавирус буюу Ковид-19 цар тахал өвчний улмаас өрхийн орлого буурсан иргэдэд тусламж дэмжлэг олгох ажлыг зохион байгуулах | - | Тусламж, дэмжлэгт хамрагдсан иргэдийн тоо | Дүүргийн 600 иргэн 25.3 сая төгрөгийн тусламж дэмжлэгт хамрагдсан. | Өрхийн орлого буурсан иргэдийг тусламж дэмжлэгт хамруулсан байна. | Коронавируст халдвар буюу Ковид-19 өвчнөөс урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, эмзэг бүлгийн иргэдийн амьдралыг дээшлүүлэх зорилгоор НЗДТГ, Миний дэлгүүр, Сансар сүлжээ дэлгүүр, Алтан жолоо групп, Дэлхийн Зөн ОУБ, Тайваний хүүхэд гэр бүлийг дэмжих сан, Кристина нобелийн сан, Монголын Улаан загалмайн нийгэмлэг, Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, Солонгос улсын “Global share” төрийн бус байгууллага болон дүүргийн ААНБ, худалдаа үйлчилгээний байгууллага, сайн дурын идэвхтнүүдтэй хамтран давхардсан тоогоор 500 өрхөд 21.7 сая төгрөг, “Нэг өрх-Нэг хүнсний багц” арга хэмжээг зохион байгуулж УОК-оос ирүүлсэн 85.6 сая төгрөгийн өртөг бүхий 1070 ширхэг хүнсний багц олгож тусламж дэмжлэг үзүүлэв. | 100 | 100% |
| Зорилт 1.2 Худалдаа үйлчилгээний байгууллагуудын эрүүл ахуй, халдвараас сэргийлэх дэглэмийн мөрдөлт, халдваргүйжүүлэлтэд хяналт тавина. | | | | | | | | |
| 4. | Худалдаа үйлчилгээний байгууллагуудад мэргэжлийн байгууллагууд хамтран хяналт шалгалт, | - | Үзлэг шалгалт зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн | 23 | 25 | Дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй Хүнсний худалдаа, үйлчилгээний 13, хоол үйлдвэрлэлийн 3, ахуйн үйлчилгээний 8, хүнсий үйлдвэр 2 барилгын материалын худалдаа 2, эмийн сан 2, арилжааны 2 банкны 3 салбар нийт 33 байгууллагад улс, нийслэл, дүүргийн Онцгой | 100 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэх | | тоо | | | комиссоос гаргасан түр журам, заавар зөвлөмжийг тухай бүр хүргүүлэн ажиллаж Мэргэжлийн хяналтын тасагтай хамтран халдвар хамгааллын дэглэм сахиж буй эсэх, иргэдийн зорчих хөдөлгөөний бүртгэл, эрүүл ахуйн дэглэм баримталж буйд 78 удаагийн үзлэг шалгалт зохион байгуулж 32 зөрчил илрүүлж илэрсэн зөрчил дутагдлыг газар дээр арилгуулах, хугацаатай үүрэг даалгавар өгөх, мэргэжлийн хяналтын байгууллагаас мэдэгдэх хуудас, албан шаардлага өгч ажиллав.<br>"Коронавируст халдвар /Ковид-19/-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам", тусгай нөхцөл шаардлагыг хангах ажлын хүрээнд худалдаа үйлчилгээний байгууллагуудад 21 хоног тутамд халдваргүйжүүлэлт хийлгэн хяналт тавьж ажиллав. | | |
| Зорилт 1.3 Ариутгал халдваргүйтгэл хийх бодисын нөөц бүрдүүлэх, нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, нийтийн тээврийн хэрэгсэлд цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн ажлыг тогтмол зохион байгуулна. | | | | | | | | |
| 5. | Айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагууд, нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд халдваргүйтэл хийлгэх арга хэмжээг зохион байгуулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100% | Дүүргийн Багахангай тохижилт ОНӨААТҮГ нь: Шинэ төрлийн коронавирус /Ковид-19/ өвчний халдвараас урьдчилан сэргийлж 1, 2 дугаар хорооны 22854м$^2$ бүхий хүүхдийн тоглоом болон сагсан бөмбөг, хөл бөмбөгийн талбайд тусгай зориулалтын мананцар үүсгэгч машинаар ариутгал халдваргүйтгэлийн ажлыг 7 хоногийн бүрийн пүрэв гаригт тогтмол хийж гүйцэтгэж байна.<br>Тайлангийн хугацаанд ариутгал, халдваргүйтгэлийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Багахангай тохижилт ОНӨААТҮГ хамтран ковид-19 цар тахалтай холбоотойгоор дүүргийн нийтийн эзэмшлийн зам талбайд ариутгал халдваргүйжүүлэлт 4 удаа, Багахангай тохижилт ОНӨААТҮГ 24 удаа нийт 28 удаа хийж, иргэд оршин суугчдын эрүүл аюулгүй ажиллаж амьдрах орчныг бүрдүүлэв. | 100 | 100% |
| 6. | Халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаа | - | Үйл ажиллагааны | - | 100% | Дүүргийн 1-р хорооны орон сууцны 3, 6 дугаар байрны 153 өрхийн 5355м2 талбайд ахуйн хортон шавьж устгах ажлыг 1 дүгээр хорооны ажлын | 90 | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | эрхэлдэг тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар орц болон зоорийн давхарт 14 хоногт 1 удаагийн халдваргүйжүүлэлтийг хуваарийн дагуу хийлгэх, халдваргүйжүүлэлтийн бодис авч нөөц бүрдүүлэх | | хэрэгжилт, хувь | | | алба, "Цеф трейд" мал эмнэлгийн үйлчилгээний албатай хамтран оршин суугч айл өрхөөс төлбөрийг гарган 1 удаа зохион байгуулав.<br>Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2021 оны А/80 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах Коронавируст /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Хангай өргөө, Их хангай сууц өмчлөгчдийн холбооны үйлчлэгчид 11 байрны нийт 47 орцонд чийгтэй цэвэрлэгээг тогтмол хийж байна.<br>Хангайн өргөө СӨХ 5 байрны 25 орцод $2135м^2$, Их хангай СӨХ 8 байрны 16 орцод $1800м^2$ талбайд хардваргүйтгэлийн ажлыг 14 хоногт 1 удаа хийж байна.<br>Коронавирус халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх болон дүүргийн Сууц өмчлөгчдийн холбоодын ажлыг сайжруулах, ажиллах боломж нөхцөлийг нэмэгдүүлэх чиглэлээр дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөр Мэдээллийн самбар, ажлын хувцас, зайнаас халуун хэмжигч, ариутгалын бодис, автомакс зэргийг хүлээлгэн өгч Засаг даргын нөөц хөрөнгөөс 1,495,000 төгрөг зарцуулав<br>Халдваргүйжүүлэлтийн зөвшөөрөлтэй Нандин өргөө ХХК дүүргийн орон сууцны 16 байрны 47 орцны $2900м^2$ талбайд халдваргүйжүүлэлтийг хийв. | | |
| Зорилт 1.4 Хүнсээр хангах мэргэжлийн ангиудтай хамтран ажиллаж, хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлнэ. | | | | | | | | |
| 7. | Хүнсээр хангах мэргэжлийн ангиудтай хамтран ажиллах гэрээ байгуулж хэрэгжилтийг хангуулан ажиллах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 90% | 100% | Болзошгүй гамшгийн үед хүнсээр хангах зорилгоор 12 хүнсний дэлгүүр, 1 эмийн сантай гэрээ байгуулан 7 хоног бүрийн мягмар, баасан гаригт хүнсний гол нэрийн 13 бүтээгдэхүүний бодит нөөцийн мэдээг гарган Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлэн ажиллаж байна. 2021 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2021 оны 05 дугаар сарын 18-ны өдөр хүртэлх хугацаанд Улаанбаатар хотоос хүнс татан авах хуваарийг 7 хоног бүр гаргаж хүнсний нөөцийн бүрдүүлэлтийг тасралтгүй хангах ажлыг зохион байгуулсан. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд Улаанбаатар хотод | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | автомашинаар зорчих QR кодыг 7 аж ахуйн нэгжид олгох ажлыг зохион байгуулав. | | |
| Дундаж үнэлгээ | | | | | | | | 95.7% |
| 2. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО | | | | | | | | |
| Зорилт 2.1.<br>**Эрүүл мэнд:** Нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэдэд эрүүл зөв амьдралын дадлыг хэвшүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ. | | | | | | | | |
| 8. | Дүүргийн Эрүүл мэндийн төвийн бүтэц орон тоог оновчтой болгож, эмч, ажилчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлж, мэргэшсэн боловсон хүчнээр хангаж, шаардлагатай тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх | - | Сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн ажилчдын тоо | 17 удаагийн сургалтад давхардсан тоогоор 34 эмч, эмнэлгийн ажилчдыг хамруулав. | Мэргэжлийн боловсон хүчнээр хангах, мэдлэг чадварыг нь дээшлүүлэх сургалтад хамруулсан байна. | Дүүргийн Эрүүл мэндийн төв нь 25 хүний бүтэц, орон тоотойгоор иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлж байна. ЭМЯ-аас томилогдсон ажлын хэсэг 2021 оны 01 дүгээр улиралд багтаан дүүргийн Эрүүл мэндийн төвийг магадлан итгэмжлэлд хамруулсан бөгөөд 03 дугаар сарын 31-ний өдөр магадлан итгэмжлэлийн гэрчилгээг авав. Эмч, эмнэлгийн ажилчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор ЭМЯ, НЭМГ болон бусад байгууллагаас цахимаар 29, танхимаар 11 удаа зохион байгуулсан сургалтад давхардсан тоогоор 98 эмч, эмнэлгийн ажилтанг хамруулсан байна. Эрүүл мэндийн төвийн дотоодын сургалтыг цахимаар 51 удаа зохион байгуулав. Тайлангийн хугацаанд байнгын ажлын байраар эмч, сувилагч, жолооч тус бүр 1, түр ажлын байраар 1 нярав, 1 асрагч нийт 5 хүнийг шинээр ажлын байраар хангаж боловсон хүчнийг нэмэгдүүлсэн байна. | 100 | 100% |
| 9. | Иргэдийн нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс урьдчилан сэргийлэх зөв дадал хэвшилд сургах, эрүүл зохистой хооллолтыг дэмжих хөдөлгөөн өрнүүлж, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, оношлогоо | 4.0 сая төгрөг, дүүргийн төсөв | Зохион байгуулсан сургалт, хамрагдсан иргэдийн тоо | 3 удаагийн сургалтанд 48 иргэн хамрагдсан. Эрт илрүүлгийн үзлэгт 1000 гаруй иргэд хамрагдсан. | Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, иргэдийн эрүүл зөв амьдралын дадлыг олгох чиглэлээр олон талт арга хэмжээ зохион байгуулсан байна. | Эрүүл мэндийн төв нь 2021 онд иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох 4 бүлэг 26 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас шалтгаалан bhemn.ub.gov.mn вэб сайт, Багахангай эрүүл мэндийн төв фэйсбүүк хуудсаар эрүүл мэндийн боловсрол олгох, цаг үеийн мэдээ, мэдээлэлтэй холбоотой 528 удаагийн зөвлөмж зөвлөгөөг байршуулан ажилласан байна.<br>Иргэдэд зориулсан сургалтыг 9 удаа танхимаар зохион байгуулж, 128 иргэнийг хамруулав.<br>2021 оны 12-р сарын 01-ний өдрийн байдлаар нийт 39299 үзлэг хийснээс 17003 иргэнийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан байна. | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | эмчилгээг сайжруулах | | | | | Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл зөв амьдралын хэв маягийг хэвшүүлж дадал олгох, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, бие бялдраа чийрэгжүүлэх, биеийн дархлааг дэмжих зорилгоор “Дасгал хөдөлгөөн хийцгээе” идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих сарын аяныг дүүргийн Засаг даргын 2021 оны А/89 дүгээр захирамжаар 2021 оны 06 дугаар сарын 02-30-ны өдрүүдэд цахимаар зохион байгуулав. БТСХ цуврал хичээлийг цахимаар 24 удаа зохион байгуулж, 4773 хандалт авсан байна. | | |
| 10. | Халдварт өвчнөөс сэргийлэх, илрүүлэх, хянах, тандах, эмчлэх үйл ажиллагааг сайжруулан өвчлөлийг бууруулах | - | Зохион байгуулсан арга хэмжээ, өвчлөлийн тоо | 2020 онд халдварт өвчин 11 бүртгэдсэн. | Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, тандалт судалгааны чиглэлээр олон талт арга хэмжээ зохион байгуулсан байна. | Сүрьеэ өвчнийг эрт илрүүлэх үзлэгт 1210, урьдчилан сэргийлэх үзлэгт 506 иргэнийг хамруулав. 2021 онд 4491 иргэнд лабораторийн шинжилгээ хийснээс түргэвчилсэн оношлуураар тэмбүү илрүүлэх шинжилгээнд 334, ДОХ илрүүлэх шинжилгээнд 348 иргэнийг хамруулсан. Үүнээс сэжигтэй 1 тохиолдол илэрснийг баталгаажих шинжилгээнд явуулсан ба эрүүл мэндийн зөвлөгөөг өгч ажиллав.<br>Товлолын дархлаажуулалтын 10 хоногийн аяныг 5, 10 дугаар сард зохион байгуулан 528 иргэнийг хамруулж 99.6%-тай байна. | 100 | 100% |
| 11. | “Эрүүл орчин-Иргэдийн сайн сайхан” III шатны арга хэмжээний төлөвлөгөөг дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулан, хэрэгжилтийг хангах | 4.0 сая төгрөг, дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | “Эрүүл орчин-Иргэдийн сайн сайхан” II шатны хөтөлбөр 90%-тай хэрэгжсэн. | Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтууд зохион байгуулна. | “Эрүүл орчин–Иргэдийн сайн сайхан” III арга хэмжээний төлөвлөгөөг 4 бүлэг 20 заалттайгаар боловсруулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны А/06 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Тус төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хэсгийг дүүргийн Засаг даргын 2021 оны А/28 дугаар захирамжаар 15 хүний бүрэлдэхүүнтэй байгуулав.<br>Архины хамааралтай 12 гэр бүлийн судалгааг шинэчлэн гаргаж, тус гэр бүлийн 23, эрүүлжүүлэх байраар үйлчлүүлсэн 32 иргэнийг мэргэжлийн сэтгэл зүйчийн сургалт, зан үйл засах цуврал сургалтад тус тус хамруулж байна. ЗДТГ-ын НХХ, Цагдаагийн хэлтэс, ГБХЗХХ, Хороодын ажлын алба хамтран 2021 онд Алтгана, Үнэгтэй, Бор үзүүр, Цайдам, Замчин Нуурын гэр хороолол | 100 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | орчимд 2 удаа хяналт шалгалт зохион байгууллаа. Байнга архи согтууруулах ундаа хэрэглэдэг, архидалт зохион байгуулдаг 16 айл өрхийн нөхцөл байдалтай танилцаж анхааруулга, сэрэмжлүүлэг зөвлөгөө өгч, хүсэлт гаргасан 2 иргэний саналыг холбогдох албан тушаалтан, байгууллагад уламжилж ажиллав.<br>ГБХЗХХ, Сэтгэцийн эрүүл мэндийн төв, "Эр зоригийн хүч" ТББ хамтран "Хорт зуршлаас урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалтыг зохион байгуулж сургалтад 126 залуу хамрагдсан байна. Мөн "Хорт зуршилгүй 100 залуу" арга хэмжээнд 1 иргэнийг хамруулж байнгын ажлын байранд зуучлаад байна.<br>Өсвөр үе, залуучуудыг аливаа хорт зуршилд автах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажлын хүрээнд 9-12 ангийн сурагчдад "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хор уршиг" сэдвээр цахим сургалтыг 2 удаа зохион байгуулж сургалтад нийт 95 хүүхэд хамрагдав. Өсвөр насны хүүхдүүд болон эцэг эхчүүд мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодисын хор уршиг, гарах үр дагаврыг таниулах, урьдчилан сэргийлэх зорилгоор цахим орчинд 7 зурагт хуудас, 8 шторкыг 6 группээр олон нийтэд түгээн 1315 иргэний хандалт аваад байна. Дэлхийн Зөн Олон Улсын байгууллагатай хамтран "Монгол Улсад ил тод байдал, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд нийгмийн эргэх хариуцлагыг бэхжүүлэх нь" төслийн 2-р үе шат буюу MASAM II төслийг 2023 он хүртэл дүүрэгт хэрэгжүүлэхээр болов. Энэхүү төслийн хүрээнд "Эр зоригийн хүч эрүүл идэвхтэй амьдрал" ТББ-тай хамтран ажиллахаар шийдвэрлэн үе шаттай сургалтуудыг зохион байгуулж эхлээд байна. | | |
| 12. | Хотын хөгжлийн индексийн анхан шатны мэдээлэл боловсруулж буй байдалд үнэлгээ хийж, 2020 оны шалгуур | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 0.5585 болж өмнөх оноос 0.0736 нэгжээр өссөн | Индексийн үзүүлэлт өссөн байна. | Хотын хөгжлийн индексийн үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэв. Хороод болон холбогдох байгууллагуудтай хамтран анхан шатны мэдээллийг цуглуулж ЭАБ-ын маягтуудыг программд тулгалт хийж хянав. Дүүргийн индексийн нэгтгэл буюу датаг 2021 оны 05 дугаар | 100 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үзүүлэлтийн түвшинг тогтоох | | | | | сарын 14-ний өдөр НЗДТГ-т хүргүүлэв. | | |
| Зорилт 2.2.<br>**Биеийн тамир:** Иргэдийг нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх нөхцөл боломжоор хангана. | | | | | | | | |
| 13. | Мэргэжлийн холбоодтой хамтран дүүрэгт улс, бүсийн чанартай тэмцээн уралдаан зохион байгуулах, иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн биеийн тамирын арга хэмжээнүүдийг зохион байгуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх | - | Зохион байгуулагдсан уралдаан тэмцээний тоо | - | Мэргэжлийн холбоодтой хамтран дүүрэгт улс, бүсийн чанартай тэмцээн уралдаан зохион байгуулах, тэмцээний төрлийг нэмэгдүүлэн шинэ спортын төрлүүдийг хөгжүүлнэ. | Дүүргийн Засаг даргын 2021 оны А/167 дугаар захирамжийн дагуу "Багахангай Марафон-2021" улсын аварга шалгаруулах тэмцээнийг Монголын хэт холын марафон гүйлтийн холбоотой хамтран 6 цагийн гүйлт, 50км, 5*10 км, 10 км, гэсэн 4 төрлөөр зохион байгуулав. Тэмцээнд 7 аймаг, 2 дүүрэг, 2 спорт хороо, 3 клубээс нийт 164 тамирчин оролцов. Улсын хэмжээнд зохион байгуулагдсан "Цахим гимнастра" арга хэмжээнд ЕБС-ийн 24 багийн 192 сурагч 3 насны ангилал, 3 ААНБ амжилттай оролцов.<br>Цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан "Эрүүл мэндийн цахим гүйлт 2021" аяныг дүүргийн хэмжээнд 2021 оны 03 дугаар сарын 15-28-ны өдрүүдэд зохион байгуулав. "Bagakhangai running-2021" аянд 76 иргэн нэгдэж, 14 хоногийн турш 1289 км замыг туулсан ба амжилттай оролцсон ААНБ, иргэдийг шагнаж урамшуулах ажлыг зохион байгуулж 552.0 мянган төгрөг зарцуулав.<br>"Иргэдийн спортын их наадам"-ын хүрээнд 2021 оны 11 дүгээр сарын 10-аас 12 дугаар сарын 06-ны өдрийн хугацаанд дүүргийн аварга шалгаруулах 5 тэмцээн зохион байгуулж 632 иргэнийг хамруулан 4.8 сая төгрөг зарцуулав. | 100 | 1100% |
| 14. | Засаг даргын дэргэдэх хөл бөмбөг, сагсан бөмбөг, гар бөмбөгийн шигшээ багийн үйл ажиллагааг тогтмолжуулах | - | Шигшээ багийн тоо, оролцсон уралдаан тэмцээний тоо, амжилт | Засаг даргын өсвөрийн шигшээ баг 6 төрлөөр байгуулагдсан. | Өсвөрийн шигшээ багийн дугуйлан секцийг тогтмолжуулан, Өсвөрийн шигшээ багийг улс, нийслэл, бүсийн чанартай тэмцээнүүдэд оролцуулах, | Засаг даргын дэргэдэх Хөл бөмбөг, Гар бөмбөг, Сагсан бөмбөгийн өсвөрийн шигшээ багийг дүүргийн Засаг даргын 2021 оны А/138 дугаар захирамжаар байгуулав.<br>Коронавируст халдвар /КОВИД-19/ цар тахалтай тэмцэх, халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдал, бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан дугуйлан секцийн үйл ажиллагааг зогсоосонтой холбогдуулан өсвөрийн шигшээ баг хичээллээгүй. "Сагсан бөмбөг"-ийн өсвөрийн | 100 | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тоо төрлийг нэмэгдүүлнэ | шигшээ багийн үйл ажиллагааг дэмжиж “Хүүхэд залуучуудын сагсан бөмбөгийн хөгжлийг дэмжих тод анар холбоо”-той хамтран ажиллахаар болоод байна. | | |
| Зорилт 2.3<br>**Боловсрол:**<br>Хүн бүрт чанартай боловсролыг тэгш хүртээмжтэй эзэмших нөхцөлийг бүрдүүлж, мэргэжлийн боловсон хүчнээр хангана. | | | | | | | | |
| 15. | Багш нарыг мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх сургалтад үе шаттай хамруулах | - | Зохион байгуулагдсан сургалт, сургалтад хамрагдсан багш нарын тоо | 12 удаагийн онлайн болон танхимын сургалтанд 118 багш хамрагдсан. | Мэргэшүүлэх болон давтан сургалтад багш нарыг хамруулна. | 2021 оны жилийн эцсийн байдлаар мэргэжил дээшлүүлэх, ур чадвараа нэмэгдүүлэх чиглэлээр давхардсан тоогоор 190 удаагийн хэлэлцүүлэг, сургалтад давхардсан тоогоор 442 багш танхим болон цахимаар хамрагдав. Хангай цогцолбор сургуулиас багшийн мэргэжил дээшлүүлэх 1, 5, 10 жилийн үндсэн сургалтад 12 багш хамрагдлаа. ЕБС, СӨБ-ын байгууллагуудын багш ажилчдын нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллуулах ажлын хүрээнд 129 айлын түрээслээд өмчлөх орон сууцанд 10 багш, ажилтныг хамруулаад байна. | 100 | 100% |
| 16. | ЕБС, СӨБ-ын сургалтын хэрэглэгдэхүүн, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг сайжруулж, хүүхдэд ээлтэй эрүүл аюулгүй орчинг бүрдүүлэх | 106.0 сая төгрөг, Улсын төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 73 төрлийн 312 ширхэг сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангасан. | СӨБ, ЕБС-ийг сургалтын хэрэглэгдэхүүн, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангаж хүүхдэд ээлтэй эрүүл аюулгүй орчинг бүрдүүлнэ. | ЕБС, СӨБ-ын сургалтын хэрэглэгдэхүүн, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг сайжруулах зорилгоор 73 төрлийн 312 ширхэг сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангав.<br>Мөн хичээлийн хоцрогдол арилгах зорилгоор дүүргийн төсвийн хөрөнгөөр Хангай цогцолбор сургуульд шаардлагатай камер, тоног төхөөрөмжийг худалдан авах ажлыг зохион байгуулж 4.3 сая төгрөг зарцуулав. ЕБС-ийн хүүхдэд зориулсан 32 видео хичээл, 4 контент, СӨБ-ын хүүхдэд зориулсан 26 төрлийн цахим хичээлийг бэлтгэн эцэг эх асран хамгаалагч хүүхдүүдэд хүргэв.<br>НБГ-аас багш нарын онлайн орчинд аюулгүй ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж Хангай цогцолбор сургуулийн хэмжээнд 37 ширхэг Bitdefender вирусийн програмыг суулгах, сериал олгов.<br>Хүүхдэд ээлтэй, эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх ажлын хүрээнд нийслэлийн хөрөнгө оруулалтаар 44 дүгээр цэцэрлэгийн барилгын гадна фасадны засварын ажлыг 69.7 сая төгрөгийн төсөвт | 100 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өртөгөөр “Ээбо пропертийз” ХХК гүйцэтгээд байна.<br>Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд Хангай цогцолбор сургуулийн дээврийн засварт 3.3, 44 дүгээр цэцэрлэгийн дээврийн засварт 1.1 сая нийт 4,4 сая төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулав. | | |
| 17. | Хүүхэд багачуудыг улс, нийслэлийн олимпиад, уралдаан тэмцээнд оролцуулах, сурагчдын авьяас чадварыг нээн хөгжүүлэх сонгон, секц, дугуйлангийн үйл ажиллагааг тогтмолжуулж, бүх талаар дэмжиж “Оюунлаг Багахангайчууд” арга хэмжээг хэрэгжүүлэх | 4.0 сая төгрөг, дүүргийн төсөв | Зохион байгуулагдсан дугуйлан, секц, амжилт гаргасан багш, сурагчдын тоо | 6 төрлийн дугуйланд 152 хүүхэд хамрагдав. Онцгой амжилт гаргасан багш сурагчдыг шагнаж урамшуулах журамын дагуу 2 багш, 2 сурагчийг 920.000 төгрөгөөр шагнаж урамшуулсан. | 3 төрлийн дугуйланд 100 хүүхэд хамруулан, улс, нийслэлийн олимпиад, уралдаан тэмцээнд амжилттай оролцсон сурагч, багшийг шагнаж урамшуулна. | Цар тахлын улмаас дугуйлан, сургалтууд танхимаар зохион байгуулагдаагүй. Дүүргийн Соёлын ордон “Бүжгийн ертөнц” цахим хаяг шинээр нээж 181 хүүхэд, залуучуудыг хамруулсан байна. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулан дуу, бүжгийн цахим уралдааныг насны ангиллаар зохион байгуулсан ба 48 хүүхдийг хамруулж 12 хүүхдийг 180.0 мянган төгрөгөөр шагнаж урамшуулав. Дүүргийн хэмжээнд цахимаар зохион байгуулагдсан 13 төрлийн уралдаан тэмцээнд 149 хүүхэд оролцсон байна.<br>ЕБС-иас 11 төрлийн уралдаан тэмцээнд 327 сурагч, СӨБ-аас 9 төрлийн уралдаан тэмцээнд 189 хүүхэд хамрагдлаа. | 100 | 70% |
| 18. | Тусгай хэрэгцээт /хөгжлийн бэрхшээлтэй/ хүүхдийг үе тэнгийнхэнтэйгээ хамт суралцах боломжийг бүрдүүлэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | Тусгай хэрэгцээт /хөгжлийн бэрхшээлтэй/ хүүхдийг үе тэнгийнхэнтэйгээ хамт суралцах нөхцөл боломжийг бүрдүүлнэ. | Дүүргийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 23 хүүхэд бүртгэлтэй байна. Тайлангийн хугацаанд “Хангай” цогцолбор сургуульд хөгжлийн бэрхшээлтэй 3 сурагч суралцаж байгаа бөгөөд сурагчдын суралцах нөхцөл бололцоог хангахаар 5 төрлийн иж бүрдлийг олгов. Боловсролын байгууллагууд тусгай хэрэгцээт хүүхдүүдтэй ажиллах ганцаарчилсан төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төслийн II шатны сургалтад ЕБС-ийн 4 багш хамрагдаж холбогдох мэдээллийг авав.<br>Жайка олон улсын байгууллагатай хамтран “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд дэмжлэг үзүүлэх“ нь төслийн хүрээнд Хангай цогцолбор сургууль, 44, 207 дугаар | 100 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цэцэрлэгүүд тус бүр 5.0 сая төгрөгийн дэмжлэг авахаар болсон ба төсөл нь 2022 оны 06 дугаар сард дууснa. Төслийн хүрээнд 1 бүлэг 6 заалт бүхий төлөвлөгөө гарган ажиллаж байна.<br>2021 оны 11 дүгээр сард Олон улсын Найрамдал зусланд хөгжлийн бэрхшээлтэй 2 хүүхдийг эмчлүүлэх, суралцах чиглэлээр 7 хоног амруулав.<br>ЗДТГ, хороод хамтран Улсын их хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, "Булган нэг үе клуб"-ын залуучуудын дэмжлэгээр хөгжлийн бэрхшээлтэй тэргэнцэр нэн шаардлагатай байгаа 6-15 насны 3 хүүхдэд эмчилгээний тусгай зориулалттай тэргэнцэр гардуулах арга хэмжээг 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулав.<br>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс 6 удаагийн хурлыг зохион байгуулж хурлаар 14 хүүхдийн асуудлыг хэлэлцэн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоож ажиллав.<br>Шийдвэрийн дагуу Дүүргийн Эрүүл мэндийн төв нь байнгын асаргаатай хүүхдүүдийг 14 хоногт 1 удаа халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан гэрийн эргэлтээр эргэж зөвлөгөө, зөвлөмжийг тухай бүр хүргэн ажиллаж байна.<br>Салбар комиссоос хөгжлийн бэрхшээлтэй 1 хүүхдэд хөгжлийн төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. | | |
| 19. | Сургууль цэцэрлэгийн цайны газрын тоног төхөөрөмжийг сайжруулж, хүүхдийг эрүүл, баталгаат хоол хүнсээр хангахад хяналт тавих | 110.0 сая төгрөг, Улсын төсөв | Үдийн цай хөтөлбөрт хамрагдах хүүхдийн тоо | 411 хүүхдийг үдийн цай хөтөлбөрт хамруулав. | Сургууль цэцэрлэгийн цайны газарт шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг гарган холбогдох дээд шатны байгууллагад уламжилна. Хяналт шалгалтыг | 2021-2022 оны хичээлийн жилд "Хангай" цогцолбор сургуулийн Үдийн цай хөтөлбөрт 411 сурагч хамрагдаж байна.<br>Нийслэлийн Боловсролын газраас ирсэн чиглэл, дүүргийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ажлын хэсэг байгуулагдаж 4 удаа боловсролын байгууллагуудын үдийн хоол, хоол үйлдвэрлэл, хүнсний бүтээгдэхүүний татан авалт, хадгалалт хамгаалалтад хяналт шалгалт зохион байгуулан зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн ба 16 зөрчлийг илрүүлэн тухай бүрт нь зөвлөмж, зөвлөгөө, зааврыг өгч ажиллав.<br>ЕБС, СӨБ-ийн байгууллагууд нь дотоод хяналтын | 100 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тогтмолжуулна. | багийг байгуулан эцэг эхийн төлөөллөөр хоолны чанар, амталгаа, хяналтыг 7 хоногт 2-3 удаа тавьж тэмдэглэл хөтлүүлж хэвшсэн байна.<br>Мөн дүүргийн Боловсролын хэлтэс нь хоол хүнсний асуудал хариуцсан мэргэжилтэнг шинээр томилон ажиллуулж байна.<br>Хангай цогцолбор сургуулийн цайны газарт шинээр солих шаардлагатай 18 нэр төрлийн тоног төхөөрөмжийн судалгааг гарган Нийслэлийн Боловсролын газарт хүргүүлэв. | | |
| 20. | Насан туршийн боловсролын төв байгуулах ажлыг холбогдох байгууллагад уламжилж, иргэд, хүүхэд, залуучуудад насан туршийн боловсрол олгох арга хэмжээг зохион байгуулах | - | Насан туршийн боловсрол эзэмжих иргэдийн тоо | Дүүргийн Насан туршийн боловсролын төвийг байгуулан 21 иргэнийг бүртгэн, 73 төрлийн 312 ширхэг сурах бичиг сургалтын хэрэглэгдэхүүнээр хангав. | Иргэд, хүүхэд залуучуудад насан туршийн боловсрол олгох арга хэмжээг зохион байгуулна. | Дүүргийн Насан туршийн боловсрол хариуцсан 2 багш 36 удаагийн сургалтад хамрагдав.<br>2021-2022 оны хичээлийн жилд “Хангай” цогцолбор сургуульд дүйцсэн хөтөлбөрөөр 4 сурагч, 6 дугаар ангид 1 сурагч элсэн суралцаж байгаа ба бичиг үсгийн сургалтад 6 иргэн суралцаж байна. Тайлангийн хугацаанд дүүргийн насан туршийн боловсрол хариуцсан 2 багш 11 ААНБ-д 10 төрлийн сэдвээр сургалт зохион байгуулж 211 иргэнийг хамруулав. Насан туршийн боловсролын үндэсний төвөөс явуулсан 12 хичээлийг БАГАХАНГАЙ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ facebook хуудсаар дамжуулан иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулав.<br>Дүүрэгт Насан туршийн боловсролын төв байгуулах, төсөв санхүүг шийдвэрлэж өгөх тухай дүүргийн Засаг даргын хүсэлтийг БШУ-ны сайд Л.Энх-Амгалан, УИХ-ын гишүүн Ц.Сандаг-Очир нарт хүргүүлээд байна. | 100 | 100% |
| Зорилт 2.4.<br>**Нийгмийн халамж:**<br>Дүүргийн хүүхэд, ахмад настан, тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-т болон амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэнэ. | | | | | | | | |
| 21. | Ажил эрхлэлдэггүй, нийгмийн халамжид хамрагддаггүй зорилтот бүлгийн өрх, иргэдийг нийгмийн хамгааллын суурь үйлчилгээнд хамруулан, хамт олны | 7.5 сая төгрөг, дүүргийн төсөв | Орлогын эх үүсвэр нэмэгдсэн өрхийн тоо | 2020 онд 10 өрхийн 5 бүлэгт 7.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон. | Зорилтот бүлгийн өрх, иргэдийг нийгмийн хамгааллын суурь үйлчилгээнд хамруулан, | Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний “Бүлгийн зохион байгуулалттайгаар төсөл хэрэгжүүлэх орлогын эх үүсвэртэй болоход дэмжлэг үзүүлэх” үйлчилгээнд ажил, хөдөлмөр эрхэлдэггүй, нийгмийн халамжид хамрагддаггүй зорилтот бүлгийн 6 өрхийн 3 төсөлд 3.8 сая төгрөгийн санхүүжилт олгох ажлыг зохион байгуулж хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж | 100 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | бүлэг бүрдүүлэн орлогын эх үүсвэртэй болгох нөхцөлийг бүрдүүлэх | | | | хамт олны бүлэг бүрдүүлэн орлогын эх үүсвэртэй болоход нь 10 өрхөд дэмжлэг үзүүлнэ. | байна. | | |
| 22. | Дүүргийн хүүхэд, ахмад настан, тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-тэй иргэдийг нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулж, нөлөөллийн олон талт арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж, амьдрах орчны нөхцөлийг сайжруулах | ХБИ- 32.0 сая төгрөг Ахмад - 57.0 сая төгрөг, дүүргийн төсөв | Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан ХБИ, ахмадын тоо | 2020 онд нийт 558 ахмад настан 84 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хөнгөлөлт тусламж олгосон. | Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулж амьжиргаанд зохих дэмжлэг үзүүлсэн байна. | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар төрөөс баримтлах бодлого, шийдвэрийг орон нутагт хэрэгжүүлэх, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих үндсэн чиг үүрэг бүхий "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөл"-ийг дүүргийн Засаг даргын 2021 оны А/11 дүгээр захирамжаар 17 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулж үйл ажиллагаагаа явуулж байна. Салбар зөвлөл нь 2021 онд 1 зорилт 13 заалттай төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Тус онд салбар зөвлөл 3 удаа хуралдаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн үйл ажиллагаа, зорилт чиглэлийг хэрэгжүүлэхээр хэлэлцэж хэрэгжилтийг хангаж ажиллав.<br>Тайлангийн хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламжид 63 иргэнийг хамруулан 10.3 сая төгрөгийг нийгмийн халамжийн сангаас зарцуулав. Мөн ахмад настны хөнгөлөлт тусламжид нийт 639 ахмад настныг хамруулж 26.5 сая төгрөгийг зарцуулсан байна. "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг"-т 6 иргэнийг хамруулан 28.0 сая төгрөгийн санхүүжилт олгов. Дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоонд улирал бүр 600.0 мянган төгрөгийн урамшуулал олгон ажиллаж байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар засвар хийж, ашиглалтад орсон 129 айлын орон сууцнаас ахмад настан 18, хөгжлийн бэрхшээлтэй 5 иргэнд түрээслээд өмчлөх хэлбэрээр орон сууц олгов. | 100 | 100% |
| 23. | Хүмүүнлэгийн | - | Төсөл | Иргэдэд Олон | Хүмүүнлэгийн | Тайваний Хүүхэд гэр бүлийг дэмжих санд 40 | 100 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | чиглэлээр гадаадын төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, зорилтот бүлгийн өрх, иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах | | хөтөлбөрт өрх, иргэний тоо | улсын төрийн бус байгууллага болон дүүргийн ХХК, ААНБ-ууд, сайн дурын идэвхтнүүдийн 69.8 сая төгрөгийн хандив, тусламж үзүүлсэн. | чиглэлээр гадаадын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллаж, зорилтот бүлгийн 50 иргэнийг хамруулна. | өрхийн 117, Кристина нобелийн хүүхдийн санд 4 өрхийн 4, нийт 44 өрхийн 121 хүүхдийг хамруулж 6.0 сая төгрөгийн тусламж дэмжлэг олгосон байна.<br>БНХАУ-ын ӨМӨЗО-ны "Улаан загалмай" байгууллагын дэмжлэгээр 200 өрхөд 5.9 сая төгрөг, БНХАУ-ын "Улаан загалмай байгууллагаас 20 өрхөд 1.2 сая төгрөгийн хүнсний тусламж, 250.0 мянган төгрөгийн 1000 ш амны хаалт хандивлав.<br>МУЗН-ээс эрүүл мэндийн онцгой үед ажиллах сайн дурын 15 идэвхтэнд зориулсан 2.4 сая төгрөгийн иж бүрэн үүргэвч цүнх, 1.6 сая төгрөгийн 10 боодол Финлянд хувцас олгов. Мөн олон улсын Улаан загалмай, Улаан хавирган сар нийгэмлэгүүдийн холбооноос 30 өрхөд 7.2 сая төгрөгийг бэлнээр олгов.<br>Коронавируст халдвар /Ковид 19/-ын цар тахалтай тэмцэх ажлын хүрээнд БНСУ-ын "Global share", "Энх Хүслэн хайрын гар" төрийн бус байгууллагатай хамтран 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдөр 43 ААНБ-ын ажилтан албан хаагчдад 100.000 ширхэг амны хаалтыг олгов. | | |
| Зорилт 2.5.<br>**Хөдөлмөр эрхлэлт:**<br>Бүх нийтийн бүрэн, бүтээмжтэй, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. | | | | | | | | |
| 24. | Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн ажил мэргэжилгүй иргэдэд мэргэжлийн чиг баримжаа олгох, жижиг зээл, төсөл хөтөлбөрт хамрагдах сургалт зохион байгуулж, ажлын байраар хангах, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж ажиллах | 3.0 сая төгрөг, дүүргийн төсөв | Өрхийн орлого нэмэгдсэн иргэдийн тоо | Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд 133 иргэн, үүнээс 19 иргэн төсөл хөтөлбөрт, 49 иргэн ажлын байраар хангагдсан. | Ажил мэргэжилгүй иргэдийг төсөл, хөтөлбөрт хамруулж, өрхийн орлогыг нэмэгдүүлсэн байна. | Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд 160 иргэн хамрагдахаас 319 иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнээс: Ганцаарчилсан зөвлөгөөг 75 иргэнд, "Дарь овооны ээжэд" ТББ-тай хамтран "Хангай" цогцолбор сургуулийн 244 сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг зохион байгуулж 1.4 сая төгрөгийг зарцуулсан байна.<br>Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор батлагдсан "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх дунд хугацааны 10 их наядын цогц төлөвлөгөө"-ний ажлын хүрээнд Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх Оролцоо төсөлд тэнцсэн 8 иргэнээс 1 дүгээр ээлжийн төсөлд 2, 7 дугаар | 100 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ээлжийн төсөлд 1 иргэн тус тус хамрагдан 2 иргэн байнгын ажлын байраар хангагдаж 2.5 сая төгрөгийн урамшуулал олгосон байна. | | |
| 25. | Зорилтот бүлгийн иргэдийг нийтийг хамарсан үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажиллах | 120.0 сая төгрөг, дүүргийн төсөв | Түр ажлын байраар хангагдсан иргэдийн тоо | Нийтийг хамарсан ажилд нийт 146 иргэнийг хамруулсан. | Түр ажлын байраар хангаж, өрхийн орлогыг нэмэгдүүлнэ. | Хороодоос ирүүлсэн төсөл, төлөвлөгөөний дагуу нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайг сайжруулах, тохижилт, хог хаягдал цэвэрлэх ажилд ажилгүй 95 иргэнийг хамруулж, 27.7 сая төгрөг зарцуулав.<br>• Хог хаягдал цэвэрлэх ажилд 16 иргэн,<br>• Зам талбайн тохижилт сайжруулж засварлах ажилд 79 иргэн түр ажлын байраар хангагдав.<br>Багахангай тохижилт ОНӨААТҮГ ногоон байгууламж, хог хаягдлын чиглэлээр 6 иргэнийг түр ажлын байраар хангав. | 100 | 100% |
| 26. | Ахмад настны орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээх ажил эрхлэлт, зөвлөх үйлчилгээг үр дүнтэй хэлбэрээр зохион байгуулах | 10.0 сая төгрөг, дүүргийн төсөв | Орлого нь нэмэгдсэн ахмадын тоо | Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд 14 ахмадад 12.4 сая төгрөгийн үйлчилгээ үзүүлсэн. | Өсвөр, хойч залуу үеийнхэнд хөдөлмөрийн дадал олгох, мэдлэг, туршлагыг өвлүүлэх ахмад мэргэжилтнүүдийг ажиллуулж, орлогыг нэмэгдүүлсэн байна. | Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх төсөл хөтөлбөрт хамрагдахаар 11 иргэний төсөл ирсэн ба 5 иргэний 4.2 сая төгрөгийн төслийг шалгаруулж санхүүжүүлэв. Боловсролын салбарт 3, төрийн захиргааны салбарт 2 иргэн тус тус зөвлөгөө мэдээллийн үйлчилгээ үзүүлж байна. Мөн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 4 иргэний 12.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгов. | 100 | 100% |
| 27. | Залуучуудыг бизнес эрхлэх сургалт, арга хэмжээнд хамруулан гараани бизнес эрхлэлтийг дэмжих | 30.0 сая төгрөг, дүүргийн төсөв | Хөтөлбөрт хамрагдсан залуучуудын тоо | “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”-т 3 багийн 6 залуу хамрагдсан. | Ажлын байрыг бий болгож, өрхийн орлогын нэмэгдүүлнэ. | “Жи Эс Эй Эс” ХХК-тай хамтран 2021 оны 08 дугаар сарын 27-ны өдөр 15-34 насны 30 залууг хамруулж, “Старт ап” сургалтыг амжилттай зохион байгуулсан ба 7 багаас 3 багийг шалгаруулан II дахь шатны арга хэмжээнд хамруулав. Дүүргээс шалгарсан 3 баг нийслэлд 18 багтай хамт шалгаруулалтад оролцож 2 баг шалгаран Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газартай гэрээ байгуулан баг тус бүр 10.0 сая төгрөгийн эргэн төлөгдөхгүй нөхцөлтэйгээр санхүүжилт авч бизнесээ эхлүүлэн ажлын байр бий болгоод байна. | 100 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 61. | Гадаад харилцааны чиглэлээрх хууль тогтоомжийн хэрэгжилтийн хангах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100% | 2021 оны Байгууллагын гадаад харилцааны чиглэлээр зохион байгуулах ажлын төлөвлөгөөг батлуулсан. Засгийн газрын 2017 оны 57 дугаар тогтоолоор баталсан "Байгууллага хоорондын гэрээ байгуулах журам"-ын дагуу гадаад улсын адил түвшний байгууллагатай гэрээ байгуулах, уг гэрээний төслийг зохих журмын дагуу хянуулж, | 30 | 30% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулсны дараа бүртгүүлэх заалтыг баримтлан ажиллаж байна. Мөн дүүргийн удирдлага, хэлтсийн дарга нарт танилцуулан ажиллалаа. Дүүргийн гадаадын зээл, буцалтгүй тусламж, техник туслалцааны хүрээнд хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн судалгаа болон тайлан гаргаж, НЗДТГ-т хүргүүлэв. Одоогоор Коронавирус буюу COVID өвчний улмаас гадаадын зарим улстай хамтран ажиллаж, туршлага судлах ажил энэ онд зохион байгуулагдаагүй байна. | | |
| Зорилт 4.3. Дүүргийн нэг цэгийн үйлчилгээ болон явуулын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | | | | | | | | |
| 62. | Явуулын нэг цонхны үйлчилгээг хөдөө, шугам замын иргэдэд хүргэх | 0.5 сая төгрөг, дүүргийн төсөв | Явуулын үйлчилгээний тоо | 3 удаа, 60 гаруй иргэнд үзүүлсэн. | Явуулын үйлчилгээг 3 удаа зохион байгуулна | Явуулын нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх журмыг шинэчлэн баталж, Дүүргийн Засаг даргын 2021 оны А/190 дүгээр захирамжаар батлагдсан мэргэжлийн байгууллагын ажлын хэсэг дүүргийн төвөөс алслагдан оршин сууж буй мал бүхий иргэд, малчин айл өрхөд 2021 оны 11 дүгээр сарын 24, 25-ны өдрүүдэд “Явуулын нэг цэгийн үйлчилгээ” үзүүллээ. Тус үйлчилгээгээр 42 өрхийн 113 иргэнд 5 төрлийн үйлчилгээг үзүүлж, 3 төрлийн 154 ширхэг тараах материал, гарын авлага тараалаа. Эрүүл мэндийн төвөөс Ковид-19 цар тахлын дархлаажуулалтын 3 дугаар тунд 78 иргэнийг вакцинд хамруулан, 21 иргэнээс 24 хүсэлт гаргасан бөгөөд дүүргийн Засаг даргын орлогч, холбогдох мэргэжилтнүүд тайлбар, мэдээллийг уулзалтын үеэр өгөв. Тус үйл ажиллагааг зохион байгуулахад дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 818.440 төгрөг зарцуулав. | 90 | 70% |
| 63. | “Иргэн таныг сонсьё” уулзалт зохион байгуулах | - | Уулзалтын тоо | Биечлэн хүлээн авч уулзсан | Уулзалтыг 6 удаа зохион байгуулна | Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/1212 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалтыг зохион байгуулах журмын хүрээнд тус дүүрэг нь иргэдтэй хийх “Иргэн таныг сонсъё” уулзалтыг 2021 оны 09 дүгээр сарын 10, 13, 15, 16-ны өдрүүдэд дүүрэгт зохион байгуулан ажилласан.<br>Уулзалтыг хуваарийн дагуу 2021 оны 09 дүгээр сарын 10-16-ны өдрүүдэд 1, 2 дугаар хорооны нутаг дэвсгэр болох Алтгана, Үнэгтэй, Бор-Үзүүр, | 90 | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Нуурын гэр хорооллын хүүхдийн тоглоомын талбай, Ахмадын хороонд тус тус зохион байгууллаа. Уулзалтад НИТХ-ын төлөөлөгч С.Эрдэнэбаяр, ИТХ-ын дарга Ф.Мөнхгэрэл, ЗДТГ-ын хэлтсийн дарга нар болон ААНБ-ын дарга, эрхлэгч, ДИТХ-ын төлөөлөгч нар оролцов. Нийт 235 иргэн оролцож, 28 иргэнээс 33 санал хүсэлт гарч, дүүргийн Засаг дарга холбогдох тайлбар мэдээллийг өгөв.<br>Коронавирусын тархалтаас хамааран эхний хагас жилд "Иргэн таныг сонсьё" уулзалт зохион байгуулагдаагүй байна. | | |
| Зорилт 4.4. Төрийн байгууллагуудын үйлчилгээнд хэрэглэгчийн үнэлгээг тогтмол хийж хэвшинэ. | | | | | | | | |
| 64. | Төрийн үйлчилгээнд сэтгэл ханамжийн судалгаа хийж, саналыг бодлого үйл ажиллагаанд тусгаж ажиллах | - | Судалгаа хийх тоо | - | Хагас жил тутам хийнэ. 2 удаа | Төрийн үйлчилгээнд иргэдийн сэтгэл ханамжийг тандан судлах, судалгааг үндэслэн төрийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор дүүргийн Улаан загалмайн хороо, Ахмадын хороотой хамтран 2021 онд 1, 2 дугаар хорооны 27 байгууллагын үйл ажиллагааны талаар 104 иргэдээс сэтгэл ханамжийн судалгааг авч нэгтгэлээ. Судалгааны дүнд дүүргийн төр захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг "Хангалттай" гэж дүгнэсэн байна.<br>Коронавирусын тархалтаас хамааран эхний хагас жилд сэтгэл ханамжийн судалгаа хийгдээгүй. | 90 | 70% |
| Зорилт 4.5 Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт үе шаттайгаар шилжүүлж, хороодоос иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ. | | | | | | | | |
| 65. | Цахим нөхөн бүрдүүлэлтийн ажлыг зохион байгуулж, захирамжлалын баримт бичигт цахим хувь үйлдэх, төрийн архивын мэдээллийн сан хөмрөгт оруулсан байгууллагуудад батлан шалгалт хийж ажиллах | - | Цахим нөхөн бүрдүүлэлт хийх байгууллагын тоо | 2020 онд 25 байгууллагын 137 боть захирамж, тушаалыг цахим хэлбэрт оруулсан. | 13 | Архивын баримтад цахим хувь үйлдэх ажлын хүрээнд архивын нэгдсэн "AMS" программд өгөгдөл шивж оруулсан харьяа байгууллагуудын баримтыг батлан шалгах ажлыг зохион байгуулж, 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 5/188 албан бичгээр Нийслэлийн архивын газарт 24 байгууллагын 105 хадгаламжийн нэгжийн 1728 баримтын 4258 хуудас баримтанд батлан шалгалт хийж хүлээлгэн өгсөн байна. | 100 | 100% |
| 66. | Албан хэрэг хөтлөлтийн https://erp.ulaanbaatar.mn/ нэгдсэн системийн | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, | Албан хэрэг хөтлөлтийн https://erp.ulaanbaatar.mn/ | 100% | Эхний хагас жилийн байдлаар байгууллагын нийт албан хаагчдад өдөр тутам баримт боловсруулах, Е-токен төхөөрөмжийг ашиглаж хэвших арга зүйн заавар, зөвлөгөө өгч ажиллаж байгаа бөгөөд | 90 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | баримт боловсруулалт цэсийг байгууллагад бүрэн нэвтрүүлэх, E-токен төхөөрөмжийг албан хэрэгцээнд хэрэглэж хэвших | | хувь | нэгдсэн системийн баримт боловсруулалт цэсийг байгууллагад нэвтрүүлж эхэлсэн. | | баримт боловсруулалтын чанар сайжирч байна. Мөн албан бичиг 2021 оны 05 сарын 24-ний өдрөөс зөвхөн тоон гарын үсгээр явдаг болсон тул байгууллагын 5 албан хаагчид э-токен төхөөрөмжийн ашиглалтын талаар ажлын байрны сургалт хийж, заавар зөвлөмж өглөө. | | |
| Зорилт 4.6 Дүүргийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг тогтмолжуулах, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх | | | | | | | | |
| 67. | Дүүргийн хэмжээний байгууллагыг нийслэлийн удирдлагын нэгдсэн систем /erp.ulaanbaatar.m/-ийн албан хэрэг хөтлөлтийн дэд систем /edoc.ulaanbaatar.mn/-д бүртгэгдсэн нийт бичгийн эргэлт, үйл ажиллагаанд нэгдсэн хяналт тавих, холбогдох арга хэмжээг авч ажиллах. | - | Дүүргийн бичгийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа | 2020 онд бичгийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9,5 хоногт шийдвэрлэх | Бичгийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа 7,5 хоногт шийдвэрлэдэг болно. | Дүүргийн хэмжээнд жилийн эцсийн байдлаар нийт 13923 нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр 4, байгууллагаар бүртгэгдсэн 1579, системээр бүртгэгдсэн 12344, хуваарилагдсан 13923, хариутай 8121, хугацаандаа хаасан 8012, хугацаа хэтэрч хаасан 109, судалж байгаа 163, хугацаа дөхсөн 147, хугацаа сунгуулсан 3, шийдвэрлэлтийн хувь 99,25 хувьтай байна. Дүүргийн хэмжээнд бичгийн шийдвэрлэлтийн дундаж хоног 6,3 байна. | 90 | 100% |
| 68. | Дүүргийн үндсэн эх үүсвэрийн байгууллагуудын ажилтан, албан хаагчдад цахим нөхөн бүрдүүлэлт, Байгууллагын ажлын үндсэн заавар, нөхөн бүрдүүлэлт, албан хэрэг хөтлөлтийн стандартын чиглэлээр шинэ тутам гарсан заавар журмын хүрээнд сургалт, арга зүйн ажлыг зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах | 0.3 сая төгрөг, дүүргийн төсөв | - Сургалтын тоо, - Хамрагдах албан хаагчийн тоо | 2020 онд 2 удаагийн сургалтаар 45 албан хаагчдыг хамруулсан. | 1 удаагийн сургалт, хамрагдах албан хаагчийн тоо 20 | Дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн албан хаагчдад zoom программаар "Тоон гарын үсгийн хэрэглээ, боловсруулалт цэсний ашиглалт сэвдээр цахим сургалт зохион байгуулж 18 албан хаагч хамрагдсан. Мөн Биеийн тамир, спорт хороонд дүүргийн Засаг даргын А/22 дугаар захирамжаар 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг зөвлөн туслах үйл ажиллагааг өөрсдийн чиг үүргийн дагуу үзүүлэн, арга зүйн удирдлагаар хангаж ажиллалаа. Дүүргийн харьяа 26 байгууллагын 28 албан хаагчдад "Баримт бичгийн стандарт 2021" сургалтыг 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулсан. Цахим нөхөн бүрдүүлэлтийн ажлын хүрээнд 2 байгууллага ажлын байранд заавар, зөвлөмж өгөөд байна. Нийтдээ 2 удаагийн сургалтаар 46 албан хаагч хамрагдаж 3 байгууллагад зөвлөн | 90 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | туслах үйлчилгээ үзүүлсэн байна. | | |
| 69. | Дүүргийн архиваас болон Засаг даргын Тамгын газрын архиваас архивын лавлагаа хуулбарыг иргэд ба ажилтан албан хаагчдад түргэн шуурхай олгож ажиллах. | - | Үйлчилгээ үзүүлэх иргэдийн тоо | 2020 онд архиваас 64 лавлагаа хуулбарыг олгосон | 90%, түүнээс дээш | 2021 оны эхний хагас жилийн байдлаар 104 баримтыг түр хугацаагаар ашиглуулж, 61 лавлагаа хуулбар хувь олгон тоо бүртгэлийн баримт бичгүүдийг бүрэн хөтөлж хэвшсэн. | 90 | 100% |
| 70. | Албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн систем erp-edoc программыг иж бүрэн ашиглах Засаг даргын Тамгын газарт ирсэн бичгийн шийдвэрлэлтийг хянах, зохион байгуулах | - | Албан бичиг шийдвэрлэлтийн дундаж хугацаа | 2020 онд албан бичгийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9 хоног болсон. | Бичгийн шийдвэрлэлтийг 8 хоногт багтаана. | Засаг даргын Тамгын газарт жилийн эцсийн байдлаар нийт 1109, нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр 2, байгууллагаар бүртгэгдсэн 126, системээр бүртгэгдсэн 981, хуваарилагдсан 1108, үүнээс хариутай 221, хугацаандаа хаасан 193, хугацаа хэтэрч хаасан 18, судалж байгаа 10, хугацаа дөхсөн 2, хугацаа сунгуулсан 0, шийдвэрлэлтийн хувь 95.73 хувь, хариугүй бичиг 888, хугацаандаа хаасан 861, хугацаа хэтэрч хаасан 11, судалж байгаа 16 шийдвэрлэлтийн хувь 99.37 хувь, нийт ирсэн бичгийн шийдвэрлэлт 96.46 хувьтай байна. Нийт ирсэн бичгийг цаг тухайд нь хүлээн авч холбогдох удирдлагууд руу шилжүүлж шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байна. | 90 | 100% |
| 71. | Засаг даргын захирамж, Тамгын газрын даргын тушаал, албан бичгийг зөвшөөрөгдсөн төслийг үндэслэн стандартын дагуу бичиж хэвлэмэл хуудсан дээр хэвлэх, хэвлэмэл хуудасны ашиглалтыг сайжруулах. | - | Албан бичгийн тоо, чанар | 2020 онд 364 баримт бичгийг стандартын дагуу гарган хэвлэмэл хуудсанд хэвлэсэн. | Монгол Улсын баримт бичгийн стандарт /MNS 5140:1, 2, 3-2011/-ыг мөрдөж ажиллана. | Жилийн эцсийн байдлаар Засаг даргын захирамж (А)-220, захирамж (Б)-20, Тамгын газрын даргын тушаал (А)-37, тушаал (Б)-99, албан бичиг 636, нийт 972 гарсныг стандартын дагуу хэвлэмэл хуудсан дээр хэвлэж Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолын хавсралт Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, Монгол Улсын баримт бичгийн стандарт /MNS 5140:1, 2, 3-2011/-ыг мөрдөн ажиллаж байна. | 90 | 100% |
| Зорилт 4.7. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг хүлээн авч, шуурхай шийдвэрлэх | | | | | | | | |
| 72. | Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан | - | Үйл ажиллагааны | 135 өргөдлийг хүлээн авч шийдвэрлэсэ | 100% | Дүүргийн хэмжээнд нийт 218 өргөдөл ирснээс ЗДТГ-т 53 /ажилд орохыг хүссэн 22, орон сууц хүссэн 16, тусламж дэмжлэг хүссэн 12/, бусад 3, | 90 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | өргөдөл гомдлыг хүлээн авч, шуурхай шийдвэрлэж, хариуг өгч хэвших | | хэрэгжилт, хувь | н | | дүүргийн харьяа байгууллагуудад-165 өргөдөл ирсэн. Үүнээс санал 4, НҮНТ-өөр дамжиж ирсэн 1 гомдол байна. Иргэдэд хариуг утсаар 118, цахим системээр 50, албан бичгээр 49 удаа өгсөн байна. Саналын хайрцаг, албаны цахим шуудан, утас, факсаар ирсэн өргөдөл гомдол, санал байхгүй.<br>Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 14 хоног, 9 цаг 25 минут байна.<br>Ирүүлсэн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, иргэдэд тухай бүр хариуг бичгээр болон амаар өгч, ажиллаж хэвшсэн бөгөөд шийдвэрлэлт 97,6%-тай байна. Дүүргийн вэб сайтад өргөдөл, гомдол, санал гэсэн цэс байршуулан, ажилтны нэр, утасны дугаар, иргэд хүлээн авах хуваарийг тавьж, иргэдийн санал хүсэлтийг нээлттэй хүлээн авах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. | | |
| Зорилт 4.8. Эрх зүйн сургалт, сурталчилгааны хүртээмжийг нэмэгдүүлнэ | | | | | | | | |
| 73. | Захирамжлалын баримт бичиг гаргах үйл ажиллагаанд хяналт тавих, холбогдох журмын хэрэгжилтийг хангах, иргэдэд нээлттэй мэдээлэх | - | Үйл ажиллагаа ны хэрэгжилт, хувь | 100 | 100% | Дүүргийн Засаг даргын 2021 оны А/43 дугаар захирамжаар захирамжлалын баримт бичиг гаргах үйл ажиллагаанд хяналт тавих журмыг батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар дүүргийн Засаг даргын А-223, Б-31, Байгууллагын даргын А-37, Б-99 тушаалын эрх зүйн үндэслэлийг хянаж, хууль, тогтоомжид нийцүүлэн гаргаж, бүртгэн дугаар олгож, цахим сан үүсгэн ажиллаж байна. Үүнээс Дүүргийн Засаг даргын шилэн дансанд 197, тушаал 87, дүүргийн вэб сайтад 154 захирамжийг тус тус байршуулаад байна. | 90 | 100% |
| 74. | Хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлыг төлөвлөх, зохион байгуулах | 1.0 сая төгрөг, дүүргийн төсөв | 4 удаа, 60 гаруй иргэнийг хамруулсан байна | 92% тай хэрэгжсэн. | 90%, түүнээс дээш | Дүүргийн хэмжээнд хууль, эрх зүйн цахим сургалтыг 46, танхимын сургалтыг 7 удаа зохион байгуулснаас ЗДТГ-аас холбогдох байгууллагуудтай хамтран 17, ААНБ-29, давхардсан тоогоор 250 гаруй иргэнийг хамруулж, нийт 59 төрлийн 300 гаруй гарын авлага, зөвлөмжийг өгч ажилласан байна. Үүнээс 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөх Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн | 90 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байдлын тухай хууль, хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар сургалт зохион байгууж, 98 төрийн албан хаагч хамрагдав.<br>Шинэчлэн найруулж байгаа болон шинээр боловсруулж буй 10 хууль, 8 журмын төсөлд иргэдээс гарсан 42 саналыг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлсэн. Мөн 38 иргэн эрх зүйн анхан шатны зөвлөгөө, мэдээлэл авсан байна. Эрх зүйн сурталчилгааны самбар болон дүүргийн вэб сайт, байгууллагынхаа Хэвлэл мэдээлэл facebook цахим хуудсаар дамжуулан 15 байгууллага 80 гаруй хууль, тогтоомжийг байршуулж ажилласан байна. | | |
| 75. | Иргэдэд хууль, эрх зүйн анхан шатны зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, зөвлөгөө мэдээллээр хангах | 0.5 сая төгрөг, дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 95% тай хэрэгжсэн. | 90%, түүнээс дээш | Тус дүүргийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны төлөвлөгөөг 2 бүлэг 20 заалттай боловсруулан, дүүргийн Засаг даргын 2021 оны А/38 дугаар захирамжаар баталгаажуулан хэрэгжилтийг ханган ажиллаж, төлөвлөгөөний биелэлт 80.4%-тай хэрэгжив.<br>Мөн Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга номыг 15 байгууллагын 50 албан хаагчид олгов.<br>Шинэчлэн найруулж байгаа 7 хууль, 8 журмын төсөлд иргэдээс гарсан 42 саналыг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлсэн. Мөн 38 иргэн эрх зүйн анхан шатны зөвлөгөө, мэдээлэл авсан байна. Эрх зүйн сурталчилгааны самбар болон дүүргийн вэб сайт, Багахангай дүүрэг-Хэвлэл мэдээлэл facebook цахим хуудсаар дамжуулан дүүргийн 15 байгууллага 80 гаруй хууль, тогтоомжийг байршуулсан.<br>Хууль, журмын төслийг дүүргийн вэб сайт, мэдээллийн самбар, facebook хуудсаар дамжуулан иргэдэд мэдээллийг тухай бүр хүргэн ажиллалаа. | 90 | 100% |
| 76. | Хуулийн салбарын “Нээлттэй хаалганы өдөрлөг” зохион | 0.3 сая төгрөг, | 2 удаа | 100% хэрэгжсэн | 100% | Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулагдаагүй боловч нийслэлийн хэмжээнд | 90 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулах | дүүргийн төсөв | | | | цахимаар зохион байгуулсаны дагуу 2 удаа мэдээ мэдээллийг Хороод, дүүргийн вэб сайт, хэвлэл мэдээллийн групп болон face-ээр дамжуулан иргэдэд хүргэсэн. Тус цахим өдөрлөгөөр дүүргийн 5 иргэн мэдээ, мэдээлэл авсан байна.<br>БХД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүх хуралдааныг Иргэний танхимд 2 удаа зохион байгуулсан. 2021.12.03-ны өдрийн байдлаар нийт 69 хэргийн нэхэмжлэл хүлээн авсан үүнээс нэгтгэсэн хэрэг 1, шийдвэрлэсэн 46, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан 4, шилжүүлсэн 4, захирамж тогтоолоор хэргийг хэрэгсэхгүй болгосон 6, үлдэгдэл 7, түдгэлзүүлсэн 1 хэрэг байна. Мөн 69 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгсөн байна. | | |
| 77. | Дүүрэгт Эрүү, иргэний хэргийн анхан шатны шүүх хуралдааныг зохион байгуулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100% | БХД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүх хуралдааныг Иргэний танхимд 2 удаа зохион байгуулсан. 2021.12.03-ны өдрийн байдлаар нийт 69 хэргийн нэхэмжлэл хүлээн авсан үүнээс нэгтгэсэн хэрэг 1, шийдвэрлэсэн 46, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан 4, шилжүүлсэн 4, захирамж тогтоолоор хэргийг хэрэгсэхгүй болгосон 6, үлдэгдэл 7, түдгэлзүүлсэн 1 хэрэг байна. Мөн 69 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгсөн байна. | 90 | 100% |
| 78. | Тогтоол шийдвэрийн биелэлт, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөны биелэлт, бусад хугацаат мэдээ тайлан гаргаж, нэгтгэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | -Тогтоол шийдвэрийн биелэлт 99.3 хувь,<br>-Нийслэл, дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт 91.1 хувь,<br>-захирамжлал | 90%, түүнээс дээш | Нийслэлийн Засаг даргын 30 захирамжийн 41 заалт, 1 албан даалгаврын 8 заалт, Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2 хурлын тэмдэглэлийн 8 заалт, нийт 57 тогтоол шийдвэрийн заалтыг хяналтад авч L.Monitoring.ulaanbaatar.mn сайтад жилийн эцсийн байдлаар тайлагнав. Монгол улсын хуулийн 14 заалт, Улсын хурлын тогтоолын 1 заалт, Ерөнхийлөгч зарлигийн 7 заалт, нийт 22 тогтоол шийдвэрийн биелэлтийг хагас жилийн байдлаар гарган НЗДТГ-ын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн ба жилийн эцсийн байдлаар 98.3%-тай хэрэгжсэн байна.<br>Нийслэлийн Засаг дарга бөгөөд улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн жилийн эцсийн | 100 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ын баримт бичгийн биелэлт | | биелэлт 87.7%-тай, 2021 оны төлөвлөгөөний биелэлт 90.4%-тай тус тус хэрэгжив.<br>Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2021 оны төлөвлөгөөний биелэлт 92%-тай хэрэгжсэн байна. Бусад хугацаат тайлан тухай бүр гарган ажиллаж байна. | | |
| Зорилт 4.9. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ. | | | | | | | | |
| 79. | Авлигаас урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах | 1.0 сая төгрөг, дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 2020 онд нийт 4 зорилт 15 бүтээгдэхүүн 92.6%-тай хэрэгжсэн | 90%, түүнээс дээш | АТГ-аас иргэд, олон нийтийг мэдээ мэдээллээр хангах, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд 7 төрлийн 50 гарын авлага, "Тат, түлх наалт 100 ш хороодоор дамжуулан ААНБ-дад хүргүүлэв.<br>АТГ-аас зохион байгуулсан цахим сургалтад дүүргийн 4 ЭБАТ хамрагдаж, мэдээ мэдээлэл авав. | 90 | 100% |
| 80. | ХАСХОМ болон нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хүлээн авч, бүртгэл хөтлөх, хяналт тавих | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100% -тай хэрэгжсэн. | 100% | Дүүргийн хэмжээнд 2020 оны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын шинэчилсэн мэдүүлэг гаргах 26 албан тушаалтан мэдүүлгээ гаргаж, цаасаар ирүүлж дууссан тул ЭБАТ-ны баталгаажилтийг хийж дуусав. ГБХЗХХ-ийн 1 албан хаагч хуулийн үйлчлэлд хамаарах болсон тул эрхийг нээн, ХОМ-ийг хүлээн авч баталгаажилт хийв. Нийтийн албанд нэр дэвшсэн 3 иргэний ХАСУМ мэдүүлгийг АТГ-хянуулахаар цахим болон цаасаар хүргүүлэв. | 90 | 100% |
| 81. | Авлига, ашиг сонирхол ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол мэдээллийг хүлээн авах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | Гомдол мэдээлэл ирээгүй | 100% | Гараагүй | 90 | 100% |
| 82. | Батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах арга хэлбэрүүдийг өргөжүүлэн иргэдэд хууль эрх зүйн мэдээ мэдээлэл, Цэргийн алба хаах хэлбэрүүдийг сурталчлах ажлыг тогтмолжуулж иргэн | 3.2 сая төгрөг, дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 2020 онд Давхардсан тоогоор 3896 иргэнд батлан хамгаалах төрийн үйлчилгээг үзүүлсэн. | Цэргийн бүртгэлийн мэдээллийн санд иргэдийн мэдээллийг бүрэн оруулах алба хаагаагүй иргэдэд Цэргийн алба хаах хэлбэрүүдийг | Батлан хамгаалахын сайд, нийслэлийн Засаг даргатай 2021 онд хамтран ажиллах гэрээнд тусгагдсан ажил үйлчилгээг хэрэгжүүлэх төрийн батлан хамгаалах үйлчилгээний чанар үр ашгийг дээшлүүлэхэд анхааран ажиллаж гэрээнд тусгагдсан 4 төрлийн 56 ажил үйлчилгээг үйл ажиллагаандаа төлөвлөн хэрэгжилтийг хангаж ажилласнаар 6 ажил үйлчилгээ дэлхий нийтийн хэмжээнд үүсээд байгаа КОВИД-19 цар тахлын улмаас түр хойшилж 38 ажил үйлчилгээ 89.3 - 97.8 хувийн биелэлттэй зохион байгуулагдсан | 90 | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | цэргийн харилцааг бэхжүүлэх | | | | сурталчилан мэдээлэл олгож зөрчлийг арилгасан байна. | байна.<br>Дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабаас зохион байгуулж байгаа үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээллийг Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цахим хуудас, ЗДТГ, хорооны болон Багахангай дүүргийн хэвлэл мэдээлэл facebook группэд байршуулан иргэдэд мэдээллийг түгээж байна. Жилийн эцсийн байдлаар 46 мэдээ мэдээллийг цахим хуудаст байршуулан иргэдэд хүргэлээ. | | |
| 83. | Өсвөр үеийн хүүхэд багачуудад эх оронч үзэл хүмүүжил төлөвшүүлэх, Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг дээшлүүлэх ажлыг дүүрэг орон нутгийн хэмжээнд холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах | 2.9 сая төгрөг, дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 8 төрлийн ажил үйлчилгээнээс 6 төрлийн ажил бүрэн хэрэгжиж 600 гаруй сурагчдад үйл ажиллагааг танилцуулан ажилласан. | 100% | “Монгол цэргийн өдөр” Зэвсэгт хүчний 100 жилийн ойг угтаж Монгол цэргийн нэгдсэн холбоо, Отгонтэнгэр их сургуулиас хамтран зохион байгуулан явуулж байгаа “Эрхмийн дээд - Монгол эр хүн” сэдэвт Эссэ бичлэгийн цахим уралдааныг удирдамжийн дагуу 2020 оны 12 дугаар сарын 22-наас 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулав. Тус арга хэмжээнд Зэвсэгт хүчин 100 жил гар зургийн уралдаанд 8 оюутан сурагч бүтээлээ ирүүлснээс 5 бүтээлийг шалгаруулан хүргүүллээ. Дүүргийн Засаг дарга Цэргийн штабаас эссэ бичлэг, гар зургийн уралдаанд бүтээлээ ирүүлсэн сурагчдыг талархал үнэ бүхий зүйлээр шагнаж урамшуулав. | 100 | 100% |
| 84. | Батлан хамгаалах яам Зэвсэгт хүчний Жанжин штабаас ирүүлсэн үүргийн дагуу дүүргийн цэргийн дайчилгааны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулан батлуулах, үүнтэй уялдуулан орон нутгийн хамгаалалтын болон орон нутгийн цэргийн сумангийн томилгоот нэгжийн бүрэлдэхүүн, салаадын үүрэг гүйцэтгэх үеийн | 0.5 сая төгрөг, дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 2020 онд төлөвлөгдсөн 3 чиглэлийн 12 үйл ажиллагаа бүрэн хэрэгжсэн6 | 100% | Нийслэлийн Засаг даргын 2021 оны н/02 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын 2021 оны мн/03 дугаар захирамжийн дагуу Зэвсэгт хүчний анги, командууд-ыг “Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах төлөвлөгөө”, “Байлдааны бэлэн байдлын дээд зэргүүдэд шилжүүлэх төлөвлөгөө”, “Орон нутгийн цэргийг байгуулах, бэлтгэлийн хангах төлөвлөгөө”-нүүдийг шинэчлэн боловсруулж, харъяа газар, хэлтсийн дарга нараар хянуулж, ЗХЖШ-ын даргаар 2021 оны 06 дугаар сарын 08-ны өдөр батлуулсан.<br>Цэргийн бүртгэлийг 2021 оны нэгдүгээр сард зохион байгуулсан дайчилгааны даалгавартай Зэвсэгт хүчний анги, байгууллагатай харилцан ажиллаж, цэргийн бэлтгэл үүрэгтнүүд болон техникийг оногдуулан дансалж, чанар байдлын судалгааг хийж холбогдох газруудад хүргүүлсэн. | 100 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | сургалт дадлагыг зохион байгуулах | | | | | Цэргийн штабын дайчилгааны онц чухал, маш нууц, нууц баримт бичгүүдийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад Батлан хамгаалахын төрийн болон албаны нууцыг хамгаалах журмын дагуу 2021 оны 12 дугаар сарын 01-ээс 02-ны өдрүүдэд тооллого хийж, нотломжийг нийслэлийн ЗДТГ-ын цэргийн штабт хүргүүлсэн. | | |
| 85. | Цэргийн алба хаах хэлбэрүүдийг сурталчлан иргэдийн цэргийн үүргийн биелэлтийг хангуулах ажлыг зохион байгуулах | 8.1 сая төгрөг, дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 2020 онд хуульд заасан алба хаах хэлбэрүүдээр 68 иргэнийг цэргийн алба хаалгаж 2600 гаруй иргэнд мэдээлэл олгосон байна | 100% | Монгол Улсын Цэргийн албаны тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2009 оны 33 дугаар тогтоол, Засгийн газрын 2021 оны 41 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн хугацаат цэргийн алба хаагаагүй цэргийн жинхэнэ алба хаах насны дээд хязгаарт хүрсэн иргэнийг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаалгахаар дүүргийн Засаг даргын 2021 оны А/40 дүгээр захирамжийн дагуу 24 иргэнд мөнгөн төлбөр тогтоон төлөлтийн явцад хяналт тавин ажиллаж байна. 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар нийслэлийн Төрийн сангийн 100200000984 тоот дансанд 16 иргэний 11.6 сая төгрөгийг төвлөрүүлээд байна.<br>Монгол Улсын Цэргийн албаны тухай хууль, Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоол, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 41 дүгээр тогтоолоор баталсан хяналтын тоонд багтаан, нийслэлийн Засаг даргын 2021 оны А/349 дүгээр захирамж, дүүргийн Засаг даргын 2021 оны А/82 дугаар захирамжийг тус тус үндэслэн 6 иргэнийг элсүүлсэн.<br>Тайлангийн хугацаанд 11 иргэн цэргийн дүйцүүлэх албыг 12-126 хоногийн үүрэг гүйцэтгэлтэйгээр алба хааж байна. Монгол Улсын Цэргийн албаны тухай хуульд тусгагдсан Цэргийн алба хаах хэлбэрүүдийн нэг болох Оюутан цэрэг цэргийн мэргэжил олгох сургалтын талаарх мэдээллийг ЕБС-ийн 12 дугаар анги төгссөн 16 сурагчдын цахим хаягаар хүргэн ажилласан. Тус сургалт цар тахлын хорио цээрийн улмаас тодорхойгүй хугацаагаар түр хойшлоод байна.<br>2021 оны Цэргийн жинхэнэ албаны татлагыг хууль | 100 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | журам дүрмийн дагуу зохион байгуулж Зэвсэт хүчний Жанжин штаб, нийслэлийн Цэрэг татлагын товчооноос ирүүлсэн тоон даалгаварыг бүрэн биелүүлсэн. | | |
| Зорилт 4.10 Хүний нөөцийн хөгжлийг хангана. | | | | | | | | |
| 86. | Дүүргийн төрийн захиргааны байгууллагуудад ажиллах төрийн албан хаагчдыг шударга, нээлттэй зарчмаар сонгон шалгаруулж төрийн албыг мэргэшсэн, чадварлаг хүний нөөцөөр бүрдүүлэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 2020 онд тусгай шалгалтанд тэнцэн Төрийн албаны зөвлөлөөс санал болгосон 5 албан хаагчийг хууль журмын дагуу албан тушаалд томилсон. | 90%, түүнээс дээш хувь | Хүний нөөцийн ил тод байдлыг хангаж ажиллах хүрээнд Засгийн газрын 2019 оны 100 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2020 оны А/121 дүгээр захирамжаар батлагдсан бүтэц, орон тооны дагуу албан хаагчдыг томилон ажиллуулж байгаа ба бүтэц орон тооноос илүү томилсон албан хаагч байхгүй байна.<br>Хүний нөөцийн ил тод байдлыг хангаж ажиллах хүрээнд Засгийн газрын 2019 оны 100 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2020 оны А/121 дүгээр захирамжаар батлагдсан бүтэц, орон тооны дагуу албан хаагчдыг томилон ажиллуулж байгаа ба бүтэц орон тооноос илүү томилсон албан хаагч байхгүй байна.<br>Энэ онд тус газарт 8 ажлын байрны сул орон тоо байгаа бөгөөд дээрх ажлын байранд тусгай шалгалт зохион байгуулах захиалгыг Нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлсэн, коронавирусын халдварын тархалтаас шалтгаалан тусгай шалгалт зохион байгуулагдаагүй байна.<br>Багахангай дүүргээс төрийн албаны ерөнхий шалгалт өгөхөөр 44 иргэн бүртгүүлээд байгаа ба тус Тамгын газраас шалгалт өгөх албан хаагчдад хууль тогтоомж, монгол хэл, мэдээлэл технологи, түүх, эдийн засаг, дүн шинжилгээ хийх чиглэлээр өдөр бүр 2 цагийн давтлага өгч, тест бөглүүлэн шалгалтад бэлтгүүлэн ажилласан.Ерөнхий шалгалтыг 3 албан хаагч өгснөөс 2 албан хаагч тэнцэн нөөцөд бүртгэгдлээ. | 100 | 100% |
| 87. | Төрийн албаны хүний нөөцийг чадавхжуулж, тасралтгүй сургаж хөгжүүлэх, цахим сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж, | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 2020 онд 80 удаагийн сургалтад албан хаагчдыг хамруулан | Цахим сургалтыг эхлүүлнэ. 90%, түүнээс дээш хувь | Байгууллагын "Төрийн албан хаагчийн сургалт" хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2021 оны төлөвлөгөөг 4 бүлэг, 12 арга хэмжээтэйгээр боловсруулж батлуулан байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хавсарган хэрэгжилтийг хангаан ажиллаж байна. Төлөвлөгөөний биелэлт жилийн | 100 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | төрийн албан хаагчдын мэдлэг чадвар, хандлагыг эрс шинэчлэх | | | мэдлэг чадварыг дээшлүүлсэн. | | эцсийн байдлаар 97 хувийн хэрэгжилттэй байна.<br>Төрийн албан хаагчийг сургаж хөгжүүлэх ажлын хүрээнд Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн богино болон дунд хугацааны сургалтад 10, Дээд шатны болон мэргэжлийн бусад байгууллагуудтай хамтарсан 84 удаагийн, цаг үеийн нөхцөл байдалд нийцсэн 47 удаагийн сургалтад нийт албан хаагчийг тухай бүр бүрэн хамруулж, мэдлэг ойлголыг дээшлүүлж ажиллав.. | | |
| 88. | Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 154,7 сая төгрөг, дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 2020 оны жилийн эцсийн байдлаар Төрийн албан хаагчийн сургалт хөтөлбөрийн биелэлт 92%, Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт 92,3%-тай хэрэгжив. | 90%, түүнээс дээш хувь | "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг 2021 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг 4 бүлэг, 13 арга хэмжээтэйгээр боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан бөгөөд жилийн эцсийн байдлаар 92 хувийн хэрэгжилттэй байна.<br>Албан хаагчдыг ажилд томилох, ажлаас чөлөөлөх, нэмэгдэл олгох асуудлыг ЗДТГ-ын даргын тушаалаар тухай бүр шийдвэрлүүлж ажиллав. Үүнд:<br>➢ Албан хаагчдыг ажилд томилох, ажлаас чөлөөлөх, нэмэгдэл олгох асуудлыг тухай бүр шийдвэрлүүлж ажиллав. Үүнд:<br>➢ 8 албан хаагчид цалингийн шатлалыг нэмэгдүүлж;<br>➢ Ур чадварын нэмэгдлийг 1 албан хаагчид шинээр олгож;<br>➢ Цолны нэмэгдлийг 2 албан хаагчид 2 хувиар нэмэгдүүлж;<br>➢ 2 албан хаагчид онцгой нөхцлийн нэмэгдлийг сарын үндсэн цалингийн 10 хувиар олгуулж;<br>➢ Ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг 7 албан хаагчид сарын үндсэн цалингийн 40 хувиар олгож;<br>➢ 4 албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг нэмэгдүүлж;<br>➢ 5 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулж, 1 албан хаагчид шинээр олгуулж<br>➢ 13 албан хаагчид нийгмийн асуудлыг нь шийдвэрлэн дэмжлэг үзүүлж;<br>➢ Санхүүгийн аудитын шалгалтаар | 100 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | "Зөрчилгүй" дүгнэгдсэн 4 албан хаагчид 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшуулал олгож тус тус шийдвэрлүүлэв. | | |
| Дундаж үнэлгээ | | | | | | | | 96% |
| ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО | | | | | | | | |
| Зорилт 5.1."Дүүрэгт ногоон байгууламжийг сайжруулах оновчтой менежментийг хэрэгжүүлэн, цэцэрлэгжүүлэх, тохижилт бүхий гудамж, талбайг бий болгож, иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ." | | | | | | | | |
| 89. | Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр иргэн, аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн санал санаачилгыг дэмжин бичил цэцэрлэгүүдийг нэмэгдүүлж өрх бүр 1 мод аян өрнүүлэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 2020 онд 1106 мод тариалсан. | Өрх бүрд 1 мод | Ойн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигийн хүрээнд "Ойн ногоон урлан" ХХК-тай хамтран<br>Мод тарих үндэсний өдрийг тохиолдуулан "Нэг өрх-нэг мод" аяныг 2021.05.17-ны өдөр модны үзэсгэлэн худалдаа зохион байгуулж иргэн аж ахуйн нэгж байгууллагуудад улиас, нарс, хуш, бор голт, хайлаас, бургас, монос, агч, өрөл, шар хуайс, тэхийн шээг, гэх мэт 12 нэр төрлийн модыг 304 иргэн 26 аж ахуйн байгууллагуудад тарааж 1046 ширхэг модыг өгч тариулсан.<br>Дүүргийн засаг даргын нөөц хөрөнгөөс 1,625,000 төгрөг зарцуулсан. | 100 | 100% |
| 90. | Дүүргийн иргэдийн хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах, хүлэмжийн аж ахуй эрхлэх боломжийг нэмэгдүүлэн, дэмжлэг үзүүлэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | Нийт 6 га талбайд тариалж 12,5 тн төмс 2,6 тн хүнсний ногоо хураан авсан. | 90 ба түүнээс дээш хувь | Дүүргийн хэмжээнд 7,9 га газарт иргэд, аж ахуйн нэгж, байгууллага хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалсан. Тус иргэдийг дэмжин,<br>дүүргийн хэмжээнд хүнсний ногоо тариалдаг иргэн, аж ахуйн нэгжүүд хүсэлт гаргасны үүднээс нарийн ногооны 8 төрлийн үрийг 43 иргэн, 2 аж ахуй нэгж байгууллагад үрийн дэмжлэг үзүүлэн ажиллав. Тус ажилд Засаг даргын нөөц хөрөнгөөс 171,084 төгрөг зарцуулсан.<br>Төмс хүнсний ногоо тариалах хүсэлт гаргасан 50 иргэнд тус бүр 10 кг үрийн төмсний дэмжлэг үзүүлж Засаг даргын нөөц хөрөнгөөс 419,000 төгрөг зарцуулсан байна. | 100 | 100% |
| Зорилт 5.2. Хог хаягдлын менежментийг сайжруулж, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэн, үйлчилгээний төлбөр, хураамж төлөх нээлттэй ил тод хялбаршуулсан цахим системийг нэвтрүүлнэ | | | | | | | | |
| 91. | Дүүргийн "Багахангай тохижилт" ОНӨААТҮГ-тай хог ачиж тээвэрлэх гэрээ, аж ахуйн нэгж, байгууллагуудтай | - | Гэрээ байгуулах ААНБ-ууд тоо | - | 55 | Дүүргийн Багахангай тохижилт ОНӨААТҮГ нь: Улаанбаатар хотын Ерөнхий менежер, дүүргийн Засаг даргатай Хог тээврийн гурвалсан гэрээ байгуулан 1, 2 дугаар хорооны нийтийн эзэмшлийн орон сууцны айл өрхийн 1146тн, гэр | 100 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тохижилт, цэвэрлэгээний гэрээ байгуулах, нийтийн эзэмшлийн зам талбай, хог хаягдал авах, цас мөсний цэвэрлэгээний хуваарь гарган батлуулан мөрдүүлэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулна | | | | | хорооллын айл өрхийн 2265тн, дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа албан байгууллага, аж ахуй нэгж байгууллагын 336тн, нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, гуу жалганы 4080тн хог хаягдлыг татан авч нийт 7827тн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт тээвэрлэн, дарж булшилсан.<br>Мөн Хороод, "Тохижилт, цэвэрлэгээний гурвалсан гэрээ", Багахангай тохижилт" ОНӨААТҮГ "Хог ачиж тээвэрлэх гэрээ"-г Төрийн байгууллага-30, Төмөр замын -10, Банк, санхүү-4, СӨХ-2, Хүнсний худалдаа-13, Барилгын материал-2, Ахуй үйлчилгээний 10, нийт-71 ААНБ болон худалдаа үйлчилгээний газруудтай байгуулах ажлыг зохион байгуулж дуусгав.<br>Тайлангийн хугацаанд нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай болон орон сууцны орцны үүдэнд ил задгай хог хаягдал хаясан ААНБ болон иргэдийг илрүүлэн дүүргийн тохижилт, хог хаягдлын олон нийтийн байцаагч нар 56 илрүүлж зөрчлийн тэмдэглэл хөтлөн шийдвэрлэж ажилласан байна. | | |
| 92. | Бүх нийтийн цэвэрлэгээг хуваарийн дагуу зохион байгуулах, холбогдох арга хэмжээг авах, хэрэгжилтэд хяналт тавих | - | Зохион байгуулах тоо | 4 | 7 | "Бүх нийтийн их цэвэрлэгээ"-г 4, Цас цэвэрлэгээ 1 удаа, "Багахангай тохижилт" ОНӨААТҮГ түүвэр цэвэрлэгээг 8 удаа зохион байгуулав.<br>Бүх нийтийн цэвэрлэгээнд: давхардсан тоогоор 121 ААНБ, иргэн 877 албан хаагч оролцож 146109 м2 талбайн үүсмэл хог хаягдлыг цэвэрлэж 39,5тн хогийг төвлөрсөн хогийн цэгт буулгав.<br>Цас цэвэрлэгээнд: Нийт 24 аж ахуйн нэгж, байгууллагын 283 ажилтан албан хаагчид оролцов.<br>Түүвэр цэвэрлэгээ 65.350м2 талбайн 21тн хог хаягдлыг татан авч дарж булшилсан.<br>Цэвэрлэгээний явцын мэдээг Улаанбаатар хотын шуурхай удирдлага зохицуулалтын төвийн /11-310005/ дугаарын утсанд мэдэгдэн, дүн мэдээг нэгтгэн dispatcher_ub@yahoo.com, УБЗАА-ны Хог хаягдлын удирдлага, зохицуулалтын хэлтэст | 100 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | munkhjargal.zaa@gmail.com и-мэйл хаягаар хүргүүлэв.<br>Бүх нийтийн их цэвэрлэгээ хийх ажлыг хороо тус бүр зохион байгуулж, цэвэрлэгээний явцад Засаг даргын Тамгын газрын Тохижилт, худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэс болон 1, 2 дугаар хорооны тохижилт, хог хаягдлын олон нийтийн байцаагч нар хяналт тавьж ажиллав. | | |
| 93. | “Шарилжгүй Улаанбаатар” аяныг зохион байгуулах, тайлан, мэдээг холбогдох байгууллагад цаг хугацаанд нь хүргэх | - | Зохион байгуулах тоо | 2 | 2 | “Харшлын эсрэг хамтдаа” уриатай “Шарилжгүй Улаанбаатар 6” аяны удирдамжийн дагуу зэрлэг ургамал устгах ажлыг 2 удаа зохион байгуулав.<br>Шарилж устгалын ажилд давхардсан тоогоор нийт 127 аж ахуйн нэгж, байгууллагын 595 ажилтан, албан хаагч, 95 өрхийн иргэд **156916**м2 талбайн шарилж цэвэрлэв.<br>Дүүргийн “Багахангай тохижилт” ОНӨААТҮГ хороо тус бүрт 1 хог тээврийн машин ажиллаж, цэвэрлэсэн **18.5 тн** ургамлыг дүүргийн мал бүхий иргэдэд малын тэжээл бэлтгэхэд нь зориулан өгсөн байна. | 100 | 100, |
| 94. | Ахуйн хог хаягдлыг цуглуулж, зөөж, тээвэрлэх, маршрут, график төлөвлөгөө, цагийн хуваарийн хэрэгжилтэд хяналт тавих | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100% | Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-тай Эрүүл ахуйн тухай, Зөрчлийн тухай, Хог хаягдлын тухай, хууль, тогтоомж, НИТХТ-ийн 2009 оны 63, 2012 оны 61 дүгээр тогтоолын хэрэгжилтийг нутаг дэвсгэртээ зохион байгуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах, орчны тохижилт, цэвэрлэгээний шаардлагыг хангуулах замаар дүүргийн өнгө үзэмжийг сайжруулахад хувь нэмэр оруулах, гадна талбайн угаалга, цэвэрлэгээ, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, ААНБ-ын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 1, 2 дугаар хорооны орон сууцны айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудын цас мөс цэвэрлэх, хог хаягдлыг авах зураглал болон цагийн хуваарийг дүүргийн Засаг даргын орлогч, Хороодын засаг даргаар баталгаажуулан 1, 2 дугаар хорооны гэр хороолол айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудад мөрдүүлэн ажиллаж байна.<br>Дүүргийн хэмжээнд хог цуглуулалт тээвэрлэлт тогтоогдсон график, цагийн хуваарийн дагуу хугацаандаа тогтмол явагдаж байна. | 90 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Багахангай тохижилт ОНӨААТҮГ нь дүүргийн хэмжээнд хог цуглуулалт тээвэрлэлт тогтоогдсон график, цагийн хуваарийг иргэд олон нийтэд сурталчлан, дүүрэг орон нутагт хийгдэж байгаа бүтээн байгуулалт, цаг үетэй холбоотой мэдээ мэдээллийг БАГАХАНГАЙ ТОХИЖИЛТ фейсбүүк хаягаар байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 141 удаа, Ковидоос урьдчилан сэргийлэх мэдээлэл 118 удаа, МАНАЙ ХОРОО МИНИЙ ГУДАМЖ-2021 группэд 98 удаа, Нийслэлийн Захирагчийн ажлын албаны UB WASTE ADMIN группээр 69 удаа, UB цэцэрлэгжүүлэлт группэд 48 удаа тус тус мэдээ оруулж иргэдэд хүргэн ажиллаж байна. | | |
| 95. | Албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс төвлөрүүлэх хогны хураамжинд хяналт тавьж төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах | - | Төвлөрүүлэх төгрөг | 19.8 сая. төгрөг | 20.0 сая төгрөг | Монгол Улсын Засгийн газраас аж ахуйн нэгж, айл өрхийг цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур, цэвэр, бохир усны төлбөр болон хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд чөлөөлөгдөөд байна.<br>Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолын дагуу энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 2020 оны 12 дугаар сарын 01-нээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд төрөөс хариуцан төлөхтэй холбогдуулан Байгаль орчин аялал жуулчлалын яаманд сар бүр гүйцэтгэлийн тайлан гаргаж хүргүүлэн 9.483.600 мянган төгрөг төвлөрүүлсэн.<br>Хог хаягдлын орлогын төлөвлөгөө 20.000.000 төгрөг төвлөрүүлэхээс 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар 17.355.784 төгрөг төвлөрч 87%-н гүйцэтгэлтэй байна.<br>Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын дагуу төсвийг хэмнэлттэй зарцуулж зайлшгүй шаардлагатайгаас бусад зардлыг гаргалгүй ажиллаж Нийгмийн даатгал, Татвар зэрэг байгууллагад өр авлагагүй.<br>Мөн сар бүр хуулийн хугацаандаа багтаан төсвийн гүйцэтгэлийн мэдээг төрийн сангаар | 100 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хянуулан Байгаль орчин аялал жуулчлалын яаманд хүргүүлэв. | | |
| 96. | Эзэнгүй муур, нохой устгах ажлыг зохион байгуулах | 12.0 сая төгрөг, нийслэлийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100% | Дүүргийн 1, 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт эзэнгүй нохой, муур устгах ажлыг 3 удаа Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай байгуулсан гэрээний дагуу "Өлтэй" ХХК, дүүргийн Багахангай тохижилт ОНӨААТҮГ хамтран зохион байгуулав.<br>Нийт 358 нохой, 51 муур устгаж, гүйцэтгэлийг УБЗАА-нд тухай бүр хүргэн ажиллаж байна. | 90 | 100% |
| Зорилт 5.3 Хүүхдийн тоглоомын талбай, орчны стандартыг мөрдүүлж, хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлж, хяналтыг сайжруулна. | | | | | | | | |
| 97. | Хүүхдийн тоглоомын талбайн эвдрэл гэмтлийг засварлах | 1.0 сая төгрөг, дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | | 100% | Дүүрэгт хүүхдийн тоглоомын талбай 9 байгаа бөгөөд ашиглалт, засвар үйлчилгээг Багахангай тохижилт ОНӨААТҮГ хариуцан ажиллаж байна.<br>Дүүргийн эрүүл мэндийн төвийн гадна талбайн тоглоомын талбайг 2-р хорооны орон сууцны байрнуудын дундах талбайд шилжүүлэн байршууллаа.<br>Хүүхдийн тоглоомын 6 талбайн аюулгүй байдалд үзлэг шалгалт хийж хүүхдийн эрүүл мэндэд эрсдэл учруулахуйц нөхцөл байдал үүссэн 55 зөрчил илрүүлэн, засч сайжруулан эрсдэлийг арилгав.<br>Хүүхдийн тоглоомын талбайн эвдрэл гэмтлийг засварлахад 727,000 төгрөг зарцуулав. | 100 | 100% |
| Зорилт 5.4 Иргэд, аж ахуйн нэгжийн хэрэгцээг бүрэн хангасан сайжруулсан шахмал түлш, хагас коксжсон түлшний хэрэглээг нэмэгдүүлж, байр, суурцны дулаалгыг сайжруулж агаарын бохирдлыг бууруулна. | | | | | | | | |
| 98. | Сайжруулсан түлшний хэрэглээ, заавар зөвлөмж, айл өрх бүрийн зуух яндангийн битүүмжлэл, аюулгүй байдал, угаарын хийнээс урьдчилан сэргийлэх заавар, зөвлөмж өгч сургалт зохион байгуулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100% | 2019 онд батлагдсан Агаарын чанарыг сайжруулах бүсэд тус дүүрэг одоогоор хамрагдаагүй түүхий нүүрс хэрэглэж байгаа тул сайжруулсан түлшний нөөц бүрдүүлэх ажил хийгдээгүй.<br>Дүүрэгт сайжруулсан түлш худалдаалах цэгийг 1-р хороонд 1, 2-р хороонд 2 байршлыг судалж байна.<br>Нийт сайжруулсан түлшээр хангагдах өрхийн тоо судалгааг гаргав.<br>Дүүргийн гэр хорооллын айл өрхүүдэд гал түймэр, угаарын хийн хордлого, осол эндэгдлээс урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтыг 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдрөөс 10 дугаар сарын | 90 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 25-ны өдрүүдэд зохион байгуулав.<br>Угаарын хий, хордлогоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээ мэдээллийг ЗДТГ, 1, 2 дугаар хороо, Онцгой байдлын хэлтэс хамтран шуурхай албаны авто машины чанга яригч ашиглан нийтийн эзэмшлийн гудамж, талбай, ус түгээх 5 цэг болон худалдаа үйлчилгээний 4 газрын ойр орчимд 8 анхаарал сэрэмжлүүлэг заавар зөвлөмжийг өгч ажилласан байна.<br>Пийшин зуухны амыг дутуу таглах, нүүрс дутуу шаталт өгөх, гар аргаар чанаргүй барьсан шавар пийшин, зуух, яндангийн бүрэн бүтэн байдал алдагдсанаас иргэд угаарын хийн хурц хордлогод орж амь насаа алдахаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг зөвлөмжийг бэлтгэн 156 ширхэг айл өрхүүдэд хүргэн ажиллав.<br>Агаарын бохирдолтой тэмцэх газарт дүүргийн энгийн болон төслийн зуухтай айл өрх, дүүрэгт бүртгэлтэй 3-15 кВт хүчин чадалтай халаалтын зуухтай айл өрх, 100 кВт-аас дээш хүчин чадал бүхий халаалтын болон уурын зуух ашигладаг 6 аж ахуйн нэгж байгууллагуудын судалгааг тус тус маягтын дагуу гарган Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газарт хүргэсэн. | | |
| 99. | Дүүрэгт баригдах баяжуулсан түлшний үйлдвэрт дэмжлэг үзүүлэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100% | Баяжуулсан түлшний үйлдвэр барих зориулалтаар хүсэлт гаргасан Таван толгой түлш ХХК-д дүүргийн Засаг даргын 2021 оны А/18 дугаар захирамжаар дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт үйлдвэрийн бүсийн урд хэсэгт 30.0 га газрыг эзэмшүүлэв. | 50 | 100% |
| Зорилт 5.5 Гэр хорооллын орчин нөхцөлийг сайжруулж био жорлон нэвтрүүлэн, хөрсний бохирдлыг багасгана. | | | | | | | | |
| 100 | Хөрсний бохирдлыг бууруулах халдваргүйжүүлэлтийн ажлыг тогтмолжуулах | 2.2 сая төгрөг, дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100% | Хөрсний бохирдлоос урьдчлан сэргийлэх зорилгоор 2021 оны 04 дүгээр сард зохион байгуулахад дүүргийн "Цеф Трейд" Мал эмнэлэг үйлчилгээний алба, хороодтой хамтран 1,2 дугаар хорооны гэр хорооллын 322 айл өрхийн ариун цэврийн байгууламж, бохирын цооногт ариутгал халдваргүйтгэлийг хийв.<br>Засаг даргын нөөц хөрөнгөөс 177,0000 төгрөг зарцуулан, халдваргүйтгэлийг ажилд Хороодын ажлын алба хяналт тавьж ажиллав. | 100 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Дүүргийн Багахангай тохижилт ОНӨААТҮГ нь: Шинэ төрлийн коронаварус /Ковид-19/ өвчний халдвараас урьдчилан сэргийлж 1, 2 дугаар хорооны 22854м$^2$ бүхий хүүхдийн тоглоом болон сагсан бөмбөг, хөл бөмбөгийн талбайд тусгай зориулалтын манацар үүсгэгч машинаар халдваргүйтгэлийн ажлыг хийж гүйцэтгэж ажиллав.<br>Тайлангийн хугацаанд ариутгал, халдваргүйтгэлийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Багахангай тохижилт ОНӨААТҮГ хамтран ковид-19 цар тахалтай холбоотой дүүргийн нийтийн эзэмшлийн зам талбайд ариутгал халдваргүйжүүлэлт 4 удаа, Багахангай тохижилт ОНӨААТҮГ 24 удаа нийт 28 удаа хийв.<br>Дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 1.600.000 төгрөг гарган хороо тус бүрд нэг өрхийг сонгож стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болгов. | | |
| | | | | | | | | 100% |
| ЗУРГАА. НИЙСЛЭЛ БА БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО | | | | | | | | |
| Зорилт 6.1. Дүүргийн 1, 2 дугаар хорооны байр, орц, гэр хорооллуудыг стандартын хаягжилттай болгоно. | | | | | | | | |
| 101 | Айл өрхийн гадна хаягжилтийг стандартад нийцүүлэн шинэчлэх | 2.0 сая төгрөг, дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100% | Нийслэлийн Засаг даргын гадна хаягийн загвар батлах тухай 2019 оны А/897 дугаар захирамжийн хүрээнд дүүргийн аж ахуйн нэгж байгууллагуудад стандартын шаардлага хангасан хаягжилт хийх талаар дүүргийн Засаг даргын 2/131 дүгээр албан бичгийг аж ахуйн нэгж байгууллагуудад хүргэн ажилласан.<br>22 ААНБ стандартын шаардлага хангасан хаягаар гадна хаягаа шинэчилсэн.<br>2 дугаар хорооны орон сууцны 11 байр, Бор-Үзүүр, Замчин, Цайдам, Нуурын гэр хорооллын айл өрхийн хашааны хаягийг "Нэгдсэн хаягжуулалт, Хаягийн бичвэрт тавих шаардлага" /MNS 6275:2011/-ын дагуу хийж гүйцэтгэхэд Засаг даргын нөөц хөрөнгөөс 1,645,400 төгрөг зарцуулав. | 100 | 100% |
| Зорилт 6.2. "Багахангай тохижилт" ОНӨААТҮГ-ын оффисын барилгын иж бүрэн ажлын зураг төсвийг боловсруулан батлуулна. | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 102 | Багахангай тохижилт ОНӨААТҮГ-ын оффисын барилгын зураг төсөв боловсруулан батлуулах | - | Боловсруулсан зураг төсөв, тоо | - | 1 | 2021 оны хөрөнгө оруулалтаар хийх санхүүжилт төсөвт тусгагдаагүй болно. | - | 0 |
| Зорилт 6.3. Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын байранд их засвар хийнэ. | | | | | | | | |
| 103 | Барилгын засварын ажилд хяналт тавих | 750.0 сая төгрөг, Нийслэлийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100% | Нийслэлийн төсвийн хөрөнгөөр Засаг даргын Тамгын газрын барилгын их засварын ажлыг "Мөнхийн үргэлжлэл" ХХК гүйцэтгэж байна. Тус ажилд 750 сая төгрөг төсөвлөсөн. | 90 | 100% |
| Зорилт 6.4. Дүүргийн 2 дугаар хорооны хатуу хучилттай авто замыг УБ-Чойр чиглэлтэй холбох 1.3 км авто замын ажлыг гүйцэтгэнэ. | | | | | | | | |
| 104 | Дүүргийн доторх болон 1, 2 дугаар хороог холбосон автозамаас босоо тэнхлэгийн авто зам хүртэлх 1.3 км авто зам барих ажлыг дуусгах | 1.6 тэрбум төгрөг, нийслэлийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 70% | 100% | Нийслэлийн төсвийн хөрөнгөөр дүүргийн 1, 2 дугаар хороог холбосон авто замаас босоо тэнхлэгийн авто зам хүртэлх 1.3 км авто зам, явган зам, дугуй зам барих 1.6 тэрбум төгрөгийн өртөгтэй ажлыг 2020-2021 онд он дамжин "Их харгуйн зам" ХХК хийж ашиглалтад хүлээн авав.<br>Тус замд нэмэлтээр ус зайлуулах хоолой, авто машины гарц хийх ажлыг нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөр шийдвэрлэн Шагайн жим ХХК шууд гэрээ байгуулах аргачлалаар шалгаруулан гэрээ байгуулах мэдэгдлийг Нийслэлийн Авто замын хөгжлийн газарт хүргүүлээд байна. | 100 | 100% |
| 6.5. Нийтийн эзэмшлийн талбайд явган хүний зам шинээр барих ажлыг үргэлжлүүлнэ. | | | | | | | | |
| 105 | Нийтийн эзэмшлийн талбайд явган хүний зам шинээр барих ажлыг үргэлжлүүлэх | 134,4 сая төгрөг, нийслэлийн төсөв | Тоо хэмжээ | 5680$м^2$ | 6321$м^2$ | Нийтийн эзэмшлийн гудамж талбайн 37 байршилд 5207$м^2$ явган зам шинээр тавих, засварлах ажлыг "Их уул зам" ХХК 2020-2021 онд дамжин 284,4 сая төгрөгөөр гүйцэтгэж ашиглалтанд оруулав.<br>Мөн Дүүргийн 1, 2 дугаар хороог холбосон автозамаас босоо тэнхлэгийн авто зам хүртэлх 1.3 км авто зам, явган зам /3900м2/, дугуй зам /2600м2/ барих ажлыг 1.6 тэрбум төгрөгийн өртөгтэй 2020-2021 он дамжин хийж дуусгав.<br>Нийт 9107 $м^2$ явган хүний замыг шинээр нэмэгдүүлээд байна. | 100 | 100% |
| 6.6. Гудамж болон хороолол дундах зам, уулзварыг шинэчлэх болон шинээр барьж байгуулан хөдөлгөөний аюулгүй байдлыг хангана. | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 106 | 1 дүгээр хорооны 5, 6 – р байрны өмнөх авто замын шинэчлэлтийн ажил | 80.0 сая. Төгрөг , нийслэлийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100% | Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 1 дүгээр хорооны орон сууцны 5, 6 дугаар байрнуудын өмнөх авто замын ажил шинээр барих ажлыг "Их харгүйн зам" ХХК гүйцэтгэж ашиглалтад хүлээж аваад байна. | 100 | 100% |
| 6.7. Дүүргийн гол, туслах авто замын засвар, шинэчлэлтийн ажил болон шинээр зам барьж байгуулна. | | | | | | | | |
| 107 | Дүүргийн доторх болон 1, 2-р хороог холбосон авто замын зорчих хэсгийн эвдрэл, хагарлыг нөхөх, засварлах | 59.6 сая. төгрөг, замын сангийн хөрөнгө | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100% | Нийслэлийн авто замын сангийн хөрөнгөөр 59,6 сая төгрөгийн өртөгтэй авто замын 500 м2 зорчих хэсгийн эвдрэл, хагарлыг нөхөж засварлах, 400 м боржур шинэчлэх, 7 ширхэг замын босоо тэмдэг, тэмдэглэгээ хийх ажлыг "Сейф транс" ХХК хийж гүйцэтгэв. Тус ажилд 59.6 сая төгрөг зарцуулав. | 100 | 100% |
| 6.8. Дүүргийн суурьшлын бүсэд тээврийн хэрэгслийн зогсоолыг шинээр барьж байгуулна. | | | | | | | | |
| 108 | 1-р хорооны 5, 6 дугаар байрны өмнөх авто зогсоолын шинэчлэлтийн ажил | 77.6 сая төгрөг, ОНХСХ | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100% | Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 1-р хорооны 5, 6 дугаар байрны өмнөх авто зогсоол барих ажлын гүйцэтгэгчээр "Сейф транс" ХХК шалгарч тус ажилд 75.6 сая төгрөг зарцуулав. | 100 | 100% |
| 6.9 Нийтийн зориулалттай орон сууцны барилгын дулааны алдагдлыг бууруулна. | | | | | | | | |
| 109 | 2 дугаар хорооны орон сууцны 3, 4, 8, 16 дугаар байрны гадна фасад хийх ажил | 160.0 сая төгрөг, нийслэлийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100% | Нийслэлийн төсвийн хөрөнгөөр дүүргийн 2-р хорооны орон сууцны 3, 4, 8, 16-р байрны гадна дулаалгын ажлыг "Талст өндөрлөг" ХХК түлхүүр гардуулах нөхцөлтэйгээр 3, 8, 16-р байрны гадна дулаалгын ажлыг гүйцэтгэхэд 160.0 сая зарцуулав.<br>Тус гүйцэтгэгч байгууллага нь /COVID 19/-тэй холбоотойгоор барилгын материалын үнэ огцом нэмэгдсэнтэй холбогдуулан шинээр төсөв хийлгэн магадлалаар орж баталгаажуулсан. /222.4 сая төгрөг/ 4-р байрны гадна дулаалгын ажил хийхэд төсөв хүрэлцээгүй. | 70 | 70% |
| 6.10. Шинэ суурьшлын бүсүүдийн цахилгаан эрчим хүчний шугам сүлжээг өргөтгөн сайжруулна. | | | | | | | | |
| 110 | Дүүргийн 1 дүгээр хорооны Үнэгтэй, 2 дугаар хорооны Замчин гэр хорооллын | 160.0 сая төгрөг, нийсл | Гэрэлтүүлгийн тоо ширхэг | - | 80ш | Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 1 дүгээр хорооны Үнэгтэй, 2 дугаар хорооны Замчин гэр хорооллын гэрэлтүүлэг тавих ажлын гүйцэтгэгчээр "Өндрийн уудам" ХХК шалгарч 84 ш гэрэлтүүлэг | 100 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | гэрэлтүүлэг шинээр тавих | элийн төсөв | | | | шинээр нэмэгдүүлэв. Тус ажилд 139.7 сая төгрөг зарцуулав. | | |
| 6.11 "Илч-Орд" ОНӨААТҮГ-ын халаалтын зуухын хүчин чадлыг нэмэгдүүлж, Өндөртолгой хотхоны хойд болон баруун жигүүрийн инженерийн шугам сүлжээг шинэчилнэ. | | | | | | | | |
| 111 | Дүүргийн 1-р хорооны баруун жигүүрийн дулаан, хэрэглээний халуун ус, хүйтэн усны 5 хос шугамыг бүрэн солих, зураг төсөв хийлгэх, шинэчлэх | 5.0 сая төгрөг, ОНХСХ | Тоо хэмжээ | | 200 метр 4 хос шугам | Дүүргийн 1 дүгээр хороонд байрлах Илч-Орд ОНӨААТҮГ-ын урд төв худгаас баруун жигүүрийн цэвэр, бохир усны шугам шинэчлэх ажлын зураг төсөв боловсруулах ажлын гүйцэтгэгчээр Гидродизайн ХХК шалгарч зураг төсвийг боловсруулж байна. Ажлын гүйцэтгэл 80%-тай байна. Тус ажилд 7.6 сая төгрөг зарцуулна. | 90 | 70% |
| 6.12 Дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн гэрэлтүүлэг, камержуулалтыг нэмэгдүүлэн, орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ. | | | | | | | | |
| 112 | Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн гэрэлтүүлгийн асалтын хувийг нэмэгдүүлэх, улирлын болон графикт үзлэг хийх, засвар үйлчилгээнд хяналт тавих | 24.0 сая төгрөг, дүүргийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 98% | 100% | Дүүргийн авто зам болон нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн нийт 723 ш гэрэлтүүлэг хэвийн ажиллаж асалт 98%-тай байна.<br>Багахангай тохилжилт ОНӨААТҮГ нь 14 хоногт 1 удаа үзлэг шалгалт хийж шалгалтын мөрөөр илэрсэн зөрчлийг тухай бүр арилган ажиллаж байна.<br>Тайлангийн хугацаанд нийтийн эзэмшлийн гудамж, талбайн гэрэлтүүлгийн засвар болон үйлчилгээнд нийт 28,0 сая төгрөг зарцуулсан байна. | 100 | 100% |
| 6.13. Гэр хорооллын бүсэд хэсэгчилсэн болон бие даасан инженерийн хангамжийг нэвтрүүлэх "Service center" дэд бүтцийн төвийг 2 дугаар хороонд барьж байгуулах ажлыг эхлүүлнэ. | | | | | | | | |
| 113 | "Service center" дэд бүтцийн төвийн зураг төсвийг эхлүүлэх | 20.0 сая, нийслэлийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100% | Гэр хорооллын бүсэд хэсэгчилсэн болон бие даасан инженерийн хангамжийг нэвтрүүлэх "Service center" дэд бүтцийн төвийг дүүргийн 2 дугаар хорооны Замчин, Нуурын гэр хороолold байгуулахаар тусгасан. энэхүү ажлыг Барилга хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатарт танилцуулан зураг төсвийн зардал 96.0 сая төгрөгийг шийдвэрлүүлэхээр болов.<br>Барилга хот байгуулалтын яаманд үнэлгээний хороо байгуулагдан 2021 оны 10 дугаар сард зөвлөх үйлчилгээний тендер зарлагдсан боловч компани оролцоогүй тул шууд гэрээ байгуулахаар компанийн судалгаа хийгдэж байна.. | 10 | 30% |
| | | | | | | | | 82.3% |
| ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 114 | Нийслэл, дүүргийн зорилтот жилийн төлөвлөгөө боловсруулан батлуулах, хэрэгжилтийг хангуулах, тайлагнах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 90%, түүнээс дээш хувь | 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдөр дүүргийн Засаг даргын "2021 оныг "Эрүүл иргэн-Хариуцлагатай дүүрэг зорилтот жил болгон зарлах тухай" А/12 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралтаар ажлын хэсгийг 15 хүний бүрэлдэхүүнтэй, хоёрдугаар хавсралтаар зорилтот жилийн хүрээнд зохион байгуулах 26 арга хэмжээний төлөвлөгөөг баталсан бөгөөд 2021 оны 4/149 дүгээр албан бичээр 26 байгууллагад хүргүүлсэн байна. Эхний хагас жилийн төлөвлөгөөний биелэлт 60.4%-тай, сүүлийн хагас жилийн биелэлт 96,1%-тай хэрэгжсэн байна. | 100 | 100% |
| 115 | Мэдээллийн ил тод байдал, үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, захирамжлалын баримтыг шилэн данс, дүүргийн вэб сайтад байршуулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100% | Дүүргийн Засаг даргын шилэн дансанд 197, тушаал 87, дүүргийн вэб сайтад 154 захирамжийг тус тус байршуулаад байна | 90 | 100% |
| 116 | Дүүргийн Засаг даргын зөвлөлийн хурлыг зохион байгуулах, үүрэг чиглэлийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг хангуулах | | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 90%, түүнээс дээш хувь | 2021 онд Засаг даргын зөвлөлийн хурлыг 5 удаа зохион байгуулж, 23 үүрэг даалгаврын хэрэгжилтийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгжээр хангуулан эргэн танилцуулж, удирдлагыг мэдээ мэдээллээр хангаж ажиллав. | 90 | 100% |
| 117 | Дүүргийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулах, нийслэлийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүргийн биелэлтийг хангуулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100% | 100% | Долоо хоног бүрийн даваа гарагт дүүргийн удирдах ажилтны цахим шуурхай хурлыг зохион байгуулж байна. Нийслэл болон дүүргийн удирдах ажилтны шуурхайн зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг баасан гарагт тайлагнаж байна. Дүүргийн удирдах ажилтны цахим шуурхай зөвлөгөөнийг нийт 44 удаа зохион байгуулж, 430 үүрэг даалгаврын хэрэгжилтийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгжээр хангуулан, биелэлт 90%-тай байна. Нийслэлийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөс өгсөн нийт 346 үүргийн биелэлтийг нэгтгэн Ulaanbaatar.mn сайтад тухай бүр | 90 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байршуулж, ажиллалаа. | | |
| 118 | Засаг даргын Тамгын газрын хурлыг зохион байгуулах, тэмдэглэл хөтлөх, үүрэг даалгаврыг хэлтэс, хороодод хүргүүлэх, биелэлтийг нэгтгэж танилцуулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 2020 онд хурлыг 5 удаа зохион байгуулж, хэрэгжилт 90%-тай байна. | 100% | Гамшгаас хамгаалах бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан хурал, уулзалтыг хориглосон тул тус хугацаанд хурлыг цахимаар нэг удаа, танхимаар 1 удаа зохион байгуулаад байна. Холбогдох үүрэг чиглэлийг тухай бүр байгууллагын ERP чат групп, Facebook хуудсанд байршуулан хэлтэс хороодод хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулан удирдлагад эргэн танилцуулж ажиллав. | 50 | 100% |
| 119 | ЗДТГ-ын үйл ажиллагаатай холбогдолтой төлөвлөгөө, тайлан биелэлт, судалгаа, мэдээлэл гаргаж, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100% | 100% | Засаг даргын Тамгын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох хэлтэс албадаас авч нэгтгэн, 49 зорилт, 139 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр төлөвлөн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.<br>Сар бүрийн 2, 4 дэх долоо хоногт ЗДТГ-ын үйл ажиллагааны тайланг хэлтэс, албадаас авч нэгтгэн, НЗДТГ-ын ТЗУХ-т тогтоосон хугацаанд хүргүүлэн ажиллав.<br>Мөн албан хаагчдын судалгаа, 0-18 хүүхдийн судалгааг шинэчлэн гаргав.<br>Гамшгаас хамгаалах бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан байгууллагад, 1, 2-р хорооны нутаг дэвсгэрт эргүүл хийх албан хаагчдын хуваарийг гарган, хэрэгжилтийг хангуулан, хяналт тавин ажиллалаа. Мөн хэлтэс, албадын ажлын байранд ажиллах албан хаагчдын хуваарийг гарган, хяналт тавилаа.<br>Засаг даргын Тамгын газрын 2021 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлан, үгчилсэн тайлан нэгтгэх шатандаа байна.<br>Хүний нөөцийн чиглэлээр 54 төрлийн судалгаа гарган удирдлагыг мэдээ мэдээллээр хангаж, холбогдох байгууллагуудад хүргүүллээ.<br>Байгууллагын ERP чат групп, Facebook хуудсанд 57 мэдээ мэдээлэл байршуулан, албан хаагчдад мэдээлэл хүргэв. | 100 | 100% |
| 120 | “Шилдэг хороо”, “Шилдэг хэсгийн ахлагчийн баг” | - | Үйл ажиллага | 2020 онд амжилттай | 100% | Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Болзолт уралдаан зарлах тухай” А/182 дугаар | 100 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | шалгаруулах болзолт уралдаанд хороодыг идэвхтэй оролцуулах | | аны хэрэгжилт, хувь | оролцсон. | | захирамжийг хороодод хүргүүлэн ажиллав.<br>09.01-ний өдөр Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, хороо хариуцсан мэргэжилтэн нар зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэн болзолт уралдаанд ашиглагдах эд материалыг 1, 2 дугаар хороонд хүлээлгэн өгч заавар чиглэл өгөн, уралдааны бэлтгэлийг хангуулан ажилласан.<br>09.15-нд 1, 2 дугаар хороо "Шилдэг хороо-Хэсгийн ахлагч шилдэг баг" болзолт уралдааны хүрээнд тайланг нэгтгэн албан бичиг боловсруулан хүргүүлэв.<br>10.22-ны өдөр "Шилдэг хороо" төрөлд 2 дугаар хороо тусгай байранд шалгаран Хүүхдийн ордоноос шагналаа гардан авлаа. | | |
| 121 | Хороодын ажлын албыг чадавхжуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах | - | Хамруулах сургалтын тоо, албан хаагчдын тоо | Нийслэл болон дүүргээс зохион байгуулсан 34 удаагийн сургалтанд хороодын ажлын албанаас давхардсан тоогоор 23 албан хаагчийг хамруулсан. | Хамруулах сургалтын тоо 20, албан хаагчдын тоо 14 | Тайлангийн хугацаанд хороодод 6 удаагийн зөвлөгөө, зааварчилгааг өгч, нийслэл болон холбогдох газруудаас ирүүлсэн үүрэг чиглэл, зөвлөмжийг хүргүүлэн, нийслэл болон дүүргээс зохион байгуулсан 18 удаагийн сургалтад хороодын ажлын албанаас 16 албан хаагчийг хамруулж, ажлын албыг чадавхжуулан ажиллалаа. Мөн хороодын хэсгийн ахлагч нарын 1-5-р сард хийж хэрэгжүүлсэн ажлыг үнэлэн, урамшууллыг олгуулав.<br>Хороодын дэргэдэх Залуучуудын хөгжлийн зөвлөлийг тус бүр 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан, захирамжийг НЗДТГ-т хүргүүлэн, үйл ажиллагааг идэвхжүүлэв.<br>Хороодын хүн амын тоон судалгааг нэгтгэн Хот байгуулалт, хөгжлийн газарт хүрүүлэв. | 90 | 100% |
| 122 | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулах, хэрэгжүүлэх, тайлагнах, үнэлж дүгнүүлэх, албан хаагчдын гүйцэтгэлийг үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулах | - | Үйл ажиллагаагаа хэрэгжилт, хувь | 100% | 100% | Дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй 22 аж ахуйн нэгж, байгууллагад Засгийн газрын хэрэг эрхлэх газрын "Аргачлал, загвар батлах тухай" 100 дугаар тушаалыг хүргүүлэн, гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан боловсруулах талаар заавар, зөвлөгөөг өгч, 22 байгууллагын төлөвлөгөөг дүүргийн Засаг даргаар батлуулан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.<br>ЗДТГ-ын албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахад арга зүйн заавар | 100 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зөвлөмжийг өгч ажиллав. Журамд заасны дагуу нэгжийн менежер-4, төрийн захиргааны 20, төрийн тусгай 3, төрийн үйлчилгээний-15, гэрээт-8 албан хаагч гүйцэтгэлийн төлөвлөгөө, 5 албан хаагч үр дүнгийн гэрээг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллав. Албан хаагчдын 2021 оны хагас жилийн гүйцэтгэлийн тайланг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор авч дүгнэв. Байгууллагын үнэлгээний багийг даргын тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, 2021 оны 12 дугаар сарын 10-ны дотор гүйцэтгэлийн тайланг авч, 51 албан хаагчийн гүйцэтгэлийг үнэлэн ЗДТГ-ын даргын тушаалаар сарын үндсэн цалингийн 36-40 хувьтай тэнцэх хэмжээний урамшуулал олголоо. | | |
| 123 | Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний тайлан"-г гарган, нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хуулийн хугацаанд нь хүргүүлэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 2020 оны 01 дүгээр сард НТАЗСЗ-д хүргүүлсэн. | 100% | Төрийн албаны зөвлөлийн "Хүний нөөцийн систем"-д албан хаагчдын 2020 оны бүрэлдэхүүн хөдөлгөөн, цалин, нэмэгдлийн өөрчлөлтийг Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжаар батлагдсан хугацаанд буюу 2021.01.05-ны өдрийн дотор шивж, ажилд томилогдсон албан хаагчдыг шинээр бүртгэн, ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчдын мэдээллийг хасалт хийн, албан хаагчдын мэдээллийг бүрэн шинэчлэв. | 100 | 100% |
| 124 | Төрийн захиргааны албан хаагчдад зэрэг дэв, түүний нэмэгдэл олгуулах | - | Зэрэг дэв олгогдсон албан хаагчийн тоо | 2020 онд 9 албан хаагчид зэрэг дэвийн нэмэгдлийг нэмэгдүүлэн, 1 албан хаагчид шинээр олгуулсан. | 5-аас доошгүй | УИХ-ын 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам"-ын дагуу болзол шалгуурыг хангасан албан хаагчдад зэрэг дэв, түүний нэмэгдэл шинээр олгуулах, зэрэг дэв ахиулах судалгааг гаргах, саналыг нэгтгэн 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлэн, 5 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулан, 1 албан хаагчид зэрэг дэв шинээр олголоо. | 100 | 100% |
| 125 | Байгууллага, хамт олон, иргэний гаргасан амжилт бүтээлийг үнэлж, шагнаж урамшуулах ажлыг | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 2020 онд 77 иргэнийг шагнаж урамшуулсан. | 100% | Ардын хувьсгалын 100 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан шагнагдах иргэдийн материал ирүүлэх албан бичгийг дүүргийн аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргүүлэн шагналын материалыг хүлээн авч холбогдох | 100 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулах | | | | | газарт уламжилснаас сар шинийн баярыг тохиолдуулан 85 иргэнийг, "Эх үрсийн баяр"-ыг тохиолдуулан 12 иргэнийг, Ардын хувьсгалын 100 жилийн ойг тохиолдуулан 62 иргэнийг, "Монголын ахмадын өдөр"-ийг тохиолдуулан 5 иргэнийг, "Хүний нөөцийн өдөр"-ийг тохиолдуулан 3 иргэнийг, "Нийслэлийн өдөр"-ийг тохиолдуулан 31 иргэнийг, "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 100 жилийн ойг тохиолдуулан 1 алба хаагчийг, МУ-д худалдааны салбар үүсч хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан 21 иргэнийг, шинэ жилийн баярыг тохиолдуулан 150, нийт 370 иргэнийг шагнаж урамшууллаа. | | |
| 126 | Засаг даргын Тамгын газар, Хороодын сүлжээний тоног төхөөрөмж, бусад хурал, зөвлөгөөний сүлжээний найдвартай байдлыг хангаж ажиллах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | Засаг даргын Тамгын газар, хороод техник тоног төхөөрөмжөөр хангагдсан. | Сүлжээний тоног төхөөрөмж, найдвартай байдал, бусад хурал, зөвлөгөөний сүлжээний аюулгүй байдлыг хангаж ажиллана. 90%, түүнээс дээш | ЗДТГ-ын техник хэрэгслийн хэвийн ажиллагааг хангах ажлын хүрээнд, ЗДТГ-ын 12 компьютер, 1-р хорооны 4 компьютер, 2-р хорооны ажлын албаны 3 компьютерыг форматлан холбогдох програм хангамж суулган, 8 принтерийг засварлан, 4 компьютерт ХАОМС программ суулгалаа.<br>ЗДТГ-ын 2 албан хаагчийн компьютерыг "PCmall" засварын газарт засварлан хэвийн үйл ажиллагааг хангав. Мөн Цэргийн штабын сүлжээний утас шинээр татан монтажилж тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангаж ажиллаж байна. | 90 | 100% |
| 127 | Батлагдсан төсвийн хүрээнд үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, өр, авлагагүй ажиллах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 90%, түүнээс дээш | 2021 онд 1399465.6 төсөв батлагдсаныг 1424135.4 болгож тодотгосноос 2021 оны жилийн эцсийн байдлаар 1423978.7 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан байна. Өөрийн орлого 6669.8 мянган төгрөг орохоос Нотариатын үйлчилгээ үзүүлж байсан иргэн Д.Батчимэг нь гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгосонтой холбогдуулан 6513.1 | 90 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мянган төгрөг орлого орж ирсэн байна.<br>Гэрэл цахилгааны зардалд 7121.3 мянган төгрөг, түлш халаалтаас 1233.8 мянган төгрөг, цэвэр бохир уснаас 3985.1 мянган төгрөгийн хэмнэлт тус тус гарсан байна.<br>Өр авлагагүй, төсвийг батлагдсан хуваарийн дагуу зарцуулж ажилласан. | | |
| 128 | Санхүүгийн сахилга, хариуцлагыг сайжруулж, МХГ, АУДИТ, бусад шалгалтад хамрагдаж акт, төлбөр, зөрчилгүй ажиллах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 90%, түүнээс дээш | ЗДТГ-ын 2020, 2021 оны санхүүгийн үйл ажиллагааны явцад хийгдсэн НАГ-ын шалгалтаар зөрчилгүй санал дүгнэлттэй гарсан ба өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн гарсан зөрчлийг давтан гаргахгүйгээр ажиллаж байна. | 90 | 70% |
| 129 | Өмч, хөрөнгийн эзэмшилт, ашиглалтыг сайжруулах, тооллого тооцоог улирал тутам хийх, төсвийн хөрөнгө, улс, нийслэл, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын дүнд бий болсон хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | Өмч хөрөнгөнд тооллого хийгдсэн, ашиглалт, бүртгэлжүүлэлт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулна. 90%, түүнээс дээш хувь | Тамгын газарт ашиглаж байгаа хөрөнгүүдийг эзэмшигч тухай бүрт нь өмч эзэмшигчийн карт хөтлүүлэн эзэмшүүлж, хөрөнгийн тооллогыг 2021 оны 4,12 дугаар сард хийсэн байна. 2021 оны жилийн байдлаар албан хаагчдад шаардлагатай техник хэрэгслээр хангах чиглэлээр Цэргийн штабт 325.0 мянган төгрөгийн үнэ бүхий бичигч, камер, дохиоллын хэрэгсэл худалдан авч хүлээлгэн өглөө.<br>Мөн нийслэлийн авто баазаас шилжүүлэн ирсэн 114400,0, мянган төгрөгийн үнэ бүхий тээврийн хэрэгсэл, байгууллагын архивт орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2026.0 мянган төгрөгийн үнэ бүхий шаардлагатай тоног төхөөрөмж /агаар цэвэршүүлэгч, баримт үдэгч, принтер лазер, тоос сорогч, цаас устгагч/-ийг, 1 дүгээр хороонд азийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 854.0 мянган төгрөгийн үнэ бүхий цаас устгагч, шүүгээний холбогдох тушаалуудыг гаргуулан данс бүртгэлд тусгав. | 90 | 100% |
| 130 | Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт, шинжилгээ үнэлгээ хийх, тайлагнах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 90% | 90%, түүнээс дээш | Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын 6.2, 6.3 дахь хэсэгт заасны дагуу тогтоосон хугацаанд 18 бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт, шинжилгээ үнэлгээ хийн, тайлан мэдээг гаргаж байна. | 70 | 100% |
| 131 | Хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, төсөл хөтөлбөрийн | - | Үйл ажиллагааны | 90% | 90%, түүнээс дээш | Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хүрээнд. 2021 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын хууль-36, Улсын Их | 90 | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах | | хэрэгжилт, хувь | | | Хурлын тогтоол-3, Ерөнхийлөгчийн зарлиг-4, Засгийн газрын тогтоол-32, Нийслэлийн Засаг даргын захирамж-44, Нийслэлийн Засаг даргын албан даалгавар-7, Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлын тэмдэглэл-20 заалт буюу нийт 146 шийдвэрийн 178 заалтыг хяналтад авч хэрэгжүүлэн ажилласан.<br>Эдгээрээс бүрэн хэрэгжсэн 113, хэрэгжих шатанд 65, тасарсан заалт байхгүй бөгөөд жилийн эцсийн байдлаар шийдвэрлэлт 86.8%-тай байна. Дээд газрын тогтоол, шийдвэр болон дүүргийн бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд улирал бүр хяналт-шинжилгээ хийж, холбогдох тайланг гарган, НЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлэн, ажиллаж байна. | | |
| 132 | ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах, үр дүнг ДИТХ-аар хэлэлцүүлэх, олон нийтэд тухай бүр нээлттэй мэдээлэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 90%, түүнээс дээш хувь | Тус журам хүчингүй болсон | | - |
| 133 | Албан хаагчдын сахилга, хариуцлага, ажлын цаг ашиглалтыг дээшлүүлэх чиглэлээр 1-ээс доошгүй ажил, арга хэмжээ санаачлан зохион байгуулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100% | Нийслэлийн ЗДТГ-ын дэргэдэх Сургалт, судалгааны төв, Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн ёс зүй, гадаад имиж бүрдүүлэлт, харилцаа хандлага" сэдэвт 5 удаагийн сургалтад Тамгын газрын болон хороодын 61 албан хаагчийг хамруулан мэдлэг ойлголтыг дээшлүүлснээр энэ онд сахилгын зөрчил гаргасан албан хаагч байхгүй байна. | 90 | 100% |
| 134 | Байгууллагын | - | Үйл | "Хөдөлмөрийн | 100% | Хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн | 100 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | “Хөдөлмөрийн дотоод журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулан шинэчлэн батлуулах | | ажиллагааны хэрэгжилт, хувь | дотоод журам”-ыг шинэчлэн шаардлага | | байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулан ЗДТГ-ын даргын 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар батлуулан албан хаагчдаар мөрдүүлэн ажиллаж байна. | | |
| 135 | Байгууллагын “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-г тодотгон шинэчлэн батлуулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-г шинэчлэх шаардлага | 100% | Байгууллагын “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-г тодотгон шинэчлэн, төсвийн шууд захирагчаар батлуулан, дүүргийн Онцгой байдлын хэлтэст хүргүүлэв. | 100 | 100% |
| 136 | Байгууллагын “Ёс зүйн хороо”-ны үйл ажиллагааг идэвхжүүлэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | “Ёс зүйн хороо”-г шинэчлэн байгуулсан | Үйл ажиллагаа тогтмолжсон байна. | Байгууллагын “Ёс зүйн зөвлөл”-ийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, чадавхжуулах хүрээнд Төрийн албаны зөвлөлөөс 7 хоног бүр тогтмол зохион байгуулсан сургалтуудад гишүүн Ц.Мягмарсүрэн, Б.Цогжавхлан, Д.Хүрэлбаатар нарыг хамрууллаа. Мөн уг сургалтад ЗДТГ-ын удирдлага, нийт албан хаагчдыг тогтмол хамруулан ажиллав. | 100 | 100% |
| 137 | Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, дархлаажуулах арга хэмжээг зохион байгуулах, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах | - | Хамруулах албан хаагчийн тоо | Жил бүр үзлэгт хамруулдаг. | 10-аас доошгүй | Цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, дархлаажуулах арга хэмжээний хүрээнд 2021 оны 02 дугаар сараас 04 дүгээр сарууддад нийт 56 албан хаагчдыг коронавирусын 1, 2-р тунд хамруулав. Мөн халдвараас сэргийлэх, дархлааг дэмжих хүрээнд албан хаагчдад тус бүр 50 ширхэг С витамин, бээлий-5 ширхэг, 2 удаагийн олголтоор /23+20/ 43 амны хаалт олгов.<br>“Эрүүл иргэн-” аяны хүрээнд эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт 16, элэгний ВС вирусийн эсрэг вакцинжуулалтад 20 албан хаагчийг тус тус хамруулав.<br>11 дүгээр сарын байдлаар удирдлага, албан хаагчдад 50 ширхэгтэй маск болон өрөө болгонд 1 литрийн санитолыг өгч албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах аяныг өрнүүлсэн.<br>2021 оны 12 дугаар сарын байдлаар цар тахлын 3 дугаар тунд 51 албан хаагч хамрагдсан бөгөөд 5 албан хаагч эрүүл мэндийн байдал болон ковид-19 тусаад эдгэрснээс хойш 21 хоногийн дараа хийлгэх хугацаа нь болоогүй байна. | 90 | **100%** |

| | | |
|---|---|---|
| **ДУНДАЖ ХУВЬ** | **91** | |
| **Дундаж үнэлгээ** | | **97.3%** |

ТАЙЛАНГ ХЯНАСАН: ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ

ЗАСАГ ДАРГА С.ЭРДЭНЭБАЯР

2021 оны 12 дугаар сарын 25-ны өдөр

ТӨЛӨВЛӨГӨӨГ ТАЙЛАГНАСАН: ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Л.САНЖИЙЖАМЦ

2021 оны 12 дугаар сарын 25-ны өдөр